



МОНГОЛБАНКНЫ ЭДЭЭЛЭЛ



Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

2020 • 02 • № 42

Б.БАТДАВАА:

ТӨВ БАНКНЫ
СУДАЛГАА БОЛОН
СТАТИСТИК МЭДЭЭЛЛҮҮД
БОДЛОГЫН
ШИЙДВЭР ГАРГАЛТЫН
МАШ ЧУХАЛ СУУРЬ
БОЛДОГ


ГАДААД ВАЛЮТЫН
АЛБАН НӨӨЦИЙГ
НЭМЭГДҮҮЛЭХ
БОДЛОГЫН АРГА
ХЭМЖЭЭНҮҮД



МОНГОЛБАНКНЫ ЭРДЭНЭСИЙН САНГААС:
МӨНГӨН ТОНОГТОЙ ХЭТ ХУТГА



ТӨЛБӨР ТООЦООГОО ЦАХИМААР ХИЙЕ



ЦАХИМ БАНК

Банкны харилцах, хадгаламжийн эсвэл картын дансаа Интернэт банкны үйлчилгээнд холбуулснаар дэлхийн хаанаас ч хүссэн цагтаа (24/7) интернэт ашиглан банкны үйлчилгээг авах боломжтой, нууцлал, хамгаалалтын өндөр систем бүхий үйлчилгээ юм.

ЦАХИМ ТӨЛБӨР ТООЦОО

- Өөрийн данс хооронд гүйлгээ хийх;
- Банкны салбар хооронд гүйлгээ хийх;
- Бусад арилжааны банк руу гүйлгээ хийх;
- Гадаад гуйвуулга хийх;
- Дансны хуулга, гүйлгээг харах;
- Дансны мэдээлэл харах;
- Банкнаас захидал, мэдээлэл хүлээн авах;
- Банк руу захидал илгээх;
- Хугацаатай хадгаламжийн хугацааг сунгах;
- Валютын арилжаатай гүйлгээ хийх.

CORONAVIRUS

СЭРЭМЖЛҮҮЛЭГ!!!

Шинэ төрлийн коронавирусийн тархалт нь агаар дуслын болон халдварлагдсан хүний хүрсэн эд зүйлс, найтааж ханиахад нь бохирдсон гадаргуугаар дамжиж тархах эрсдэлтэй тул интернэт ашиглан цахим банкны үйлчилгээг сонгож хайртай хүмүүсээ хамгаалъя.

Онцлох үйл явдал:

ХУУДАС

Монголбанкны Ерөнхийлөгч ОУВС, ЖАЙКА-ийн Ази, Номхон далайн бүсийн V хуралд оролцлоо

4

Ярилцлага:

ХУУДАС

Б.Батдаваа: Төв банкны судалгаа болон статистик мэдээллүүд бодлогын шийдвэр гаргалтын маш чухал суурь болдог

5

Инфографик:

ХУУДАС

Гадаад валютын албан нөөц 2016-2020 он

8

Монголбанкны Эрдэнэсийн сангаас:

ХУУДАС

Мөнгөн тоногтой хэт хутга

12

Нийтлэл:

ХУУДАС

Японд ажилласан өдрүүд

13

Эдийн засаг энгийнээр:

ХУУДАС

Гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх бодлогын арга хэмжээнүүд

15

Монголбанкны**мэдээлэл:**

ХУУДАС

Хоёрдугаар сард 952 кг үнэт металл худалдан авлаа

17

Монголбанк юу хийдэг вэ?

ХУУДАС

А.Ананд: Макро зохистой бодлогыг зөвхөн хязгаарлах зорилготой гэж ойлгож болохгүй

19

Дэлхийн эдийн засаг:

ХУУДАС

"Ковид-19" вирусийн түүхий эдийн зах зээлд үзүүлэх нөлөө

23

Мөнгөн тэмдэгтийн түүх:

ХУУДАС

Ардын хувьсгалын 50, 60 жилийн ойд зориулан гаргасан 1 төгрөгийн зоос

27

Банкир:

ХУУДАС

Норихико Като: Банкнийг олон нийтийн болгох нь хөгжлийн эерэг бөгөөд чухал шат юм

28

Судалгаа шинжилгээ:

ХУУДАС

Иргэдийн хадгаламжид мэдээллийн тэгш бус байдал нөлөөлөх нь

33



МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ ЦАХИМААР ХУРАЛДАВ

Тус хурлаар Монголбанкны Хяналтын зөвлөлөөс 2019 онд Монголбанкны удирдлагад хүргүүлсэн зарим санал зөвлөмжийн хэрэгжилтийн байдалтай танилцлаа. Энэ хүрээнд Монголбанкны үйл ажиллагааны ашиг алдагдлын тэнцвэрийг хангах, санхүүгийн тайлангийн үр ашгийн үзүүлэлтүүд, шинэ стандартын дагуу хийгдэх хөрөнгийн үнэлгээ, эрсдэлийн тооцоололд онцгой анхаарал тавьж ажилласан байдалтай танилцлаа. Түүнчлэн уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэхэд өөрийн орны санхүүгийн хязгаарлагдмал нөөцийг зөв ашиглах харилцан уялдаа бүхий макро-мөнгөний болон макро-сангийн бодлогыг хэрэгжүүлэх арга механизм, олон улсын тэргүүний туршлагыг хамтран судалж, хэрэгжүүлсэн тухай мэдээлэл сонслоо.



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ ОУВС, ЖАЙКА-ИЙН АЗИ, НОМХОН ДАЛАЙН БҮСИЙН V ХУРАЛД ОРОЛЦОО

Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн 2020 оны 2 дугаар сарын 12-13-ны Токио хотноо болсон Олон Улсын Валютын Сангийн Ази Номхон далайн бүсийн оффис, Японы Олон улсын Хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-ийн Тавдугаар хуралд оролцлоо. Уг хурал нь “Хөгжиж буй Ази: Төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж тогтвортой, хүртээмжтэй өсөлтөд хүрэх нь” сэдвийн дор болсон бөгөөд Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн уг хурлын дэд хэсэгт дээрх сэдвийн хүрээнд танилцуулга хийлээ. Түүнчлэн Японы Сангийн яам, ОУВС болон ЖАЙКА-ийн төлөөллүүдтэй албан уулзалтууд хийж, Монгол Улсын эдийн засгийн байдал, хэрэгжүүлж буй бодлогын талаар танилцуулан цаашдын хамтын ажиллагаагаа бэхжүүлэх чиглэлээр санал солилцов.



2006 ОНЫ 20000 ТӨГРӨГИЙН ДЭВСГЭРТИЙГ ГҮЙЛГЭЭНЭЭС ТАТНА

Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар 2006 онд үйлдвэрлэсэн 20000 төгрөгийн дэвсгэртийг 2020 оны гуравдугаар сарын 1-ний өдрөөс эхлэн гүйлгээнээс татахаар боллоо. 2006 оны энэхүү дэвсгэртийн шууд танигдах хамгаалалтын элемент хангалтгүйгээс хуурамчаар үйлдэж байгаа тохиолдол нэмэгдэж байгаа тул уг дэвсгэртээр төлбөр тооцоо хийхийг зогсоож, харин иргэд 2022 оны гуравдугаар сарын 1-ний өдөр хүртэл банкууд болон Монголбанкинд шинэ дэвсгэртээр солиулах юм. 2006 оны 20,000 төгрөгийн дэвсгэрт нь ямар нэгэн цонхгүй, туузгүй, ар талын зүүн доод буланд 2006 гэсэн тоотой.



ШИНЭЧИЛСЭН ХАМГААЛАЛТЫН ЭЛЕМЕНТ БҮХИЙ МӨНГӨН ТЭМДЭГТҮҮДИЙГ ГҮЙЛГЭЭНД ГАРГАЛАА

Монголбанк нөөцийг нь дахин бүрдүүлэх шаардлагатай болсон 50, 20000 төгрөгийн дэвсгэртийг орчин үеийн технологи бүхий хамгаалалтын шинэ элементүүдээр шинэчлэн сайжруулж, гүйлгээнд гаргав. Шинэчилсэн хамгаалалтын элементүүд нь хуурамчаас ялгарч танигдахад зориулагдсан микро оптик, хөдөлгөөнт гадаргуутай тууз болон 3 хэмжээст өнгө нь хувирагч элементтэй. Түүнчлэн харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан товгор тэмдэглэгээтэй болсноороо онцлог юм.



Б.БАТДАВАА: ТӨВ БАНКНЫ СУДАЛГАА БОЛОН СТАТИСТИК МЭДЭЭЛЛҮҮД БОДЛОГЫН ШИЙДВЭР ГАРГАЛТЫН МАШ ЧУХАЛ СУУРЬ БОЛДОГ

Судалгаа, статистикийн газрын захирал Б.Батдаваатай ярилцлаа.

Төв банкны судалгааны ач холбогдлын талаар юуны өмнө ярилцахыг хүсч байна.

Дэлхийн олон орны Төв банкууд бодлого, шийдвэр гаргахдаа судалгаа, шинжилгээний ажлуудад үндэслэдэг. Иймдээ ч Төв банкууд судалгааг ихэд анхаарч, чухалчилж авч үзэх болсон. Манай газар Монголбанкны бодлогын шийдвэрт дэмжлэг болохуйц эдийн засаг, санхүүгийн салбарын холбогдолтой судалгааны ажлыг гүйцэтгэж байна. Бид судалгаа, шинжилгээгээ эдийн засгийн өмнө тулгарсан сорилтуудыг шийдвэрлэх, бодлогын хувилбаруудыг боловсруулахад чиглүүлэхийг хичээдэг.

Тухайлбал, эдийн засаг, санхүүгийн салбарын үйл ажиллагаа болон зах зээлийн нөхцөл байдлыг тодорхойлсон судалгааны ажлуудыг гүйцэтгэж, эдгээрийн үр дүн, санал зөвлөмж нь бодлогын шийдвэр гаргалтын суурь болдог. Мөн эдийн засагт шинээр үүссэн нөхцөл байдлын талаар,

түүнд тохирсон бодлогын санал дэвшүүлсэн цаг үеийн шинжтэй шинжилгээ, судалгаануудыг гүйцэтгэхийг зорьж байна.

Түүнчлэн улирал бүр иргэд, аж ахуйн нэгжүүд, банк зэрэг эдийн засгийн харилцаанд ордог бүх агентуудын хүлээлтийн түүвэр судалгааг тогтмол гүйцэтгэдэг. Үүнийг Монголбанкны төсөөллийн загваруудад өгөгдөл болгон ашиглаж байна. Ер нь зах зээлд оролцогчдын эдийн засгийн төлөв байдлын талаарх хүлээлт нь эдийн засгийн төсөөлөл гаргах, бодлого боловсруулахад чухал мэдээлэл болдог.

Тэгвэл сүүлийн үед ямар чиглэлийн судалгаан дээр төвлөрч ажиллаж байна вэ?

Манай газар 2020 оны төлөвлөгөөнийхөө дагуу нилээд олон судалгаан дээр ажиллаж байна. Тухайлбал, сүүлийн үед ихээр яригдах болсон тэтгэврийн тогтолцоо, түүний шинэчлэлийн талаар

олон улсын туршлага болоод боломжит бодлогын санал дэвшүүлсэн судалгааны ажил, төрөөс хэрэгжүүлдэг халамжийн бодлогууд хүмүүсийн хөдөлмөрлөх сонирхол, улмаар хөдөлмөрийн нийлүүлэлтэд хэрхэн нөлөөлж байгаа талаарх судалгааны ажил болон макро эдийн засагт бий болох аливаа эрсдэлийг урьдчилан тооцож, таних зорилгоор нэгдсэн тэргүүлэгч индикаторууд бүхий загвар боловсруулахаар ажиллаж байна. Мөн гадаад валютын ханшийн өөрчлөлт нь аж ахуйн нэгжүүдийн тэнцэл буюу борлуулалтын орлого, өрийн хэмжээ, хөрөнгийн үнэлгээ гэх мэт үзүүлэлтүүдэд хэрхэн нөлөөлж байгааг микро тоон мэдээлэлд үндэслэн тогтоохоор ажиллаж байна.

Түүнчлэн “Санхүүгийн дэд бүтцийн хөгжлийн үнэлгээ”, “Банкны өөрийн хөрөнгийн зохистой харьцаа, түүний зээлийн нийлүүлэлт болон эдийн засагт үзүүлэх нөлөө” зэрэг судалгаануудаас гадна Монгол Улсын хэмжээнд ашиглаж буй бэлэн болон бэлэн бус төлбөрийн хэрэгслийн талаарх түүвэр судалгааг явуулахаар бэлтгэл ажлаа ханган ажиллаж байна.

Тэгвэл бодлогын шийдвэрийнхээ үр дүнтэй байдлыг шинжилсэн судалгааг хангалттай түвшинд хийж чадаж байна уу? Жишээлбэл, макро зохистой бодлого хэрэгжүүлээ шүү дээ.

Тэгэлгүй яахав, мөнгөний бодлого болон бусад бодлогуудын үр дүн, тэдгээрийн эдийн засагт үзүүлж буй үр нөлөөг тодорхойлох шинжилгээ, судалгааны ажлуудыг тогтмол хийж гүйцэтгэдэг. Түүнчлэн бодлогын хэрэгжилтийг хөндлөнгөөс үнэлж дүгнэхийн тулд эдийн засаг, банк, санхүүгийн чиглэлээрх бусад судалгааны байгууллагатай тогтмол хамтран ажилладаг. Тухайлбал, Монголбанкнаас 2017 онд хэрэгжүүлсэн мөнгөний бодлогын үр дүн, хэрэгжилтийн талаарх судалгааг хөндлөнгийн судалгааны байгууллагаар 2018 онд хийлгэж, судалгааны үр дүнг судлаач, олон нийтэд танилцуулан хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Макро зохистой бодлогын хувьд бид Санхүүгийн зохицуулах хороотой хамтран макро зохистой бодлогын үр нөлөө нь бусад санхүүгийн байгууллагуудын зээлийн эрэлтэд хэрхэн нөлөөлж байгаа болон тус салбарт макро зохистой бодлогын арга хэрэгслүүдийг нэвтрүүлэх боломжийн талаарх судалгаануудыг хийж байна. Эдгээр судалгааны ажлуудын үр дүн, тэдгээрээс гарах бодлогын санал зөвлөмжүүд нь санхүүгийн системийн эрсдэлийг бууруулж тогтвортой

байдлыг хангахад чиглэсэн цаашдын бодлогын шийдвэр гаргалтад чухал нөлөө үзүүлнэ гэж бодож байна.

Тухайлбал, дээрх судалгаануудаас ямар үр дүн хүлээгдэж байна вэ. Бодлогын шийдвэр гаргалтад чухал нөлөө үзүүлнэ гэдгийг илүү тодруулахыг хүсье?

Банк бус санхүүгийн байгууллагын хэрэглээний зээлийн өсөлтөд банкуудад хэрэгжүүлсэн макро зохистой бодлогын нөлөөнөөс гадна бусад хүчин зүйлс буюу финтекийн өсөлт, ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгийн өсөлт нь нөлөөлсөн байна. Цаашид, банк бус санхүүгийн салбарт макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзвэл үүнээс үүдэн гарах бусад эрсдэлүүдийг анхаарч үзэх, нарийн тооцоолох хэрэгтэй гэдгийг бидний хийсэн судалгааны үр дүнгүүд харуулдаг. Иймд, санхүүгийн салбарт аливаа бодлогын шийдвэр гаргахдаа суурь судалгаа, шинжилгээнүүдийн үр дүнг тал талаас нь хэлэлцэж ажиллана.

Судалгаанаас гадна статистик үзүүлэлт бодлогын шийдвэрт мөн чухал байр суурийг эзэлдэг. Улс орны эдийн засгийн нөхцөл байдлын гол толь нь статистик мэдээллүүд болдог. Энэ утгаараа статистик үнэн зөв гарах нь бодлогын шийдвэр оновчтой гарах, улмаар үр дүнг нэмэгдүүлэхэд маш чухал.

Төв банкны хувьд статистик мэдээллийн үнэн зөв, итгэлтэй байдлыг нэмэгдүүлэх, статистик мэдээллийн хүртээмжийг сайжруулах чиглэлээр хэрхэн ажиллаж байна вэ?

Статистик мэдээлэл нь макро эдийн засаг, банк санхүүгийн салбар, зах зээлийн үйл ажиллагаа зэрэг эдийн засгийн төлөв байдлыг бүхэлд нь дүрслэх, тодорхойлох хэмжүүр тул Монголбанкны бодлого гэлтгүй аливаа төрийн болон аж ахуйн нэгжийн бодлого, шийдвэрт чухал байр суурийг эзэлдэг. Өөрөөр хэлбэл, аливаа бодлогын газрын зураг, чиглүүлэгч луужин гэж хэлэхэд тохирох болов уу. Нөгөө талд, үнэн зөв статистик мэдээлэл нь чанартай судалгаа гүйцэтгэх болон бодлогын шийдвэр гаргахад маш чухал.

Ер нь статистик мэдээллийн ил тод байх шаардлага хэр тавигдах болсон бэ?

Дэлхийн нийтэд статистик мэдээллийн чанарыг хангах асуудал маш чухлаар тавигддаг. Аливаа статистикийн чанар хангах гэдэгт тухайн мэдээллийг үнэн зөв олон улсын стандартын дагуу гаргах, цаг хугацааны хувьд аль болох

боломжит хугацаанд боловсруулах, статистик гаргахад шаардлагатай нэгжээс мэдээллийг бүрэн авч, хамруулах, хэрхэн олон нийтэд тархааж буй байдал зэрэг шалгуурыг авч үздэг. Зарим олон улсын байгууллагууд статистик мэдээллийг олон нийтэд зарлах тусгайлсан шалгуур үзүүлэлтүүдийг гаргаж, уг шаардлагын дагуу мэдээллээ түгээхийг шаарддаг. Манай улс ОУВС-ийн Мэдээлэл түгээх ерөнхий системээс Мэдээлэл түгээх тусгай стандартад 2019 онд шилжсэн. Энэ нь Монголбанкнаас гаргаж буй статистик мэдээллийн ил тод байдал хүлээн зөвшөөрөгдсөн гэсэн үг юм.

Түүнчлэн бид Монголбанкнаас боловсруулдаг статистик тоон мэдээллийг ашиглахад илүү хялбар болгох үүднээс 2020 оны эхний хагаст багтаан Монголбанкны статистикийн цахим хуудсыг нэвтрүүлэхээр ажиллаж байна.

Манай улс ерөнхийдөө импорт давамгайлсан эдийн засгийн бүтэцтэй. Эндээс үзэхэд манай хэрэглээнд зарцуулагддаг зардал, бүтээмжээс өгч байгаа өгөөж хоёрын харьцаа ямар үр дүнг үзүүлдэг вэ?

Манайд хийгдсэн судалгаа, шинжилгээнээс үзэхэд уул уурхайгаас бусад салбарт экспортын орлогоос илүүтэй импортын орц давамгайлдаг. Энэ нь цаашлаад гадаад валютын нөөц, ханшид дарамт учруулдаг. Иймд эдийн засгийг төрөлжүүлэх, уул уурхайн бус экспортын хэмжээг нэмэгдүүлэх, импортыг орлох тал дээр илүү анхаарч, ахиц гаргаж чадвал үр өгөөж, бүтээмжийг нэмэгдүүлж чадах болов уу.

Тэгвэл иргэдийн хэрэглээг судалсан ямар судалгаанууд хийгдсэн бэ, үр дүн нь хэрхэн гардаг вэ?

Иргэдийн хэрэглээ, зээлийн чанар цаашлаад санхүүгийн тогтвортой байдлыг микро тоон өгөгдөл ашиглан судлах нь илүү оновчтой байдаг. Монголбанк 2016 оноос эхлэн энэ төрлийн тоог өгөгдлийг ашиглан гүйцэтгэдэг микро суурьтай судалгааны ажил гүйцэтгэхэд анхаарах болсон. Үүний хүрээнд өрхийн хэрэглээтэй холбоотой хэд хэдэн судалгааны ажлуудыг ҮСХ-ны Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа болон манай Статистикийн хэлтэс дээр нэгтгэгддэг банкны салбарын дэлгэрэнгүй тоон мэдээллийг ашиглан гүйцэтгэсэн байгаа. Үр дүнгээс товч дурдахад банкны салбарт хэрэглээний зээлийн хэмжээ тухайн жилүүдэд тогтвортой нэмэгдсэн нь өрхийн хэрэглээг хумих замаар эдийн засгийн идэвхжлийг сааруулж улмаар санхүүгийн тогтвортой байдалд

сөргөөр нөлөөлөх эрсдэл үүсээд байгааг тогтоосон. Энэ үр дүн нь Монголбанкнаас сүүлийн жилүүдэд хэрэгжүүлж эхлээд байгаа макро зохистой бодлогын арга хэрэгслүүтэй нийцтэй байгаа юм.

Мөнгөний бодлогын шийдвэр гаргалт, хэрэгжилтэд судалгааны үр дүн мэдээж чухал хөшүүрэг болох тул арга аргачлалаа сайжруулахад хэрхэн анхаарч ажиллаж байна вэ?

Мэдээж судалгааны арга аргачлалаа тогтмол сайжруулж байх шаардлагатай. Бид тоон мэдээллийг өндөр түвшинд шуурхай боловсруулах боломжтой сүүлийн үеийн програмууд болох E-views, Stata, Matlab зэрэг програмуудыг албан ёсны эрхтэйгээр судалгаандаа ашиглаж байна. Энэ нь судалгааны тооцоолол шинжилгээг чанартай гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлдэг. Мөн эдгээр програмуудыг ашиглахаас гадна эдгээр програм дээр шууд гүйцэтгэх боломжгүй тооцоолуудыг гүйцэтгэх нэмэлт програм (add-ins)-уудыг боловсруулдаг. Бидний боловсруулсан нэмэлт програмуудыг олон улсын түвшинд эдийн засгийн судлаачид өргөнөөр ашигладаг. Тухайлбал, Зүүн Өмнөд Азийн Төв банкуудын холбоо (SEACEN) болон бусад олон улсын байгууллагууд судалгаа, сургалтдаа ашиглаж байна.

Түүнчлэн судалгаа, шинжилгээний чанарт хөндлөнгийн санал, шүүмж чухал байр суурийг эзэлдэг. Иймд манай газар судалгааны ажлуудаа хурал, хэлэлцүүлгүүдэд тогтмол танилцуулж бусад эдийн засгийн судлаачдын санал, шүүмжийг сонсож, дараа дараагийн судалгаандаа тусгахыг хичээдэг.

Эмпирик судалгаанаас гадна түүвэр судалгааны аргачлалаа сайжруулахад мөн анхаарч байгаа бөгөөд манай түүвэр судалгааны аргачлал сүүлийн жилүүдэд нэлээд сайжирсан. Тухайлбал, бид түүвэр судалгаандаа Дэлхийн банкны "САРИ" системийг нэвтрүүлэн таблет ашиглан гүйцэтгэх болсон. Ингэснээр бага зардлаар богино хугацаанд чанартай тоо мэдээлэл цуглуулах боломж бүрдсэн.


Дашрамд дурдахад, сүүлийн жилүүдэд Монголбанкны судлаачид эдийн засгийн нэр хүнд бүхий олон улсын сэтгүүлүүдэд судалгааны ажлуудаа тогтмол хэвлүүлж байна. Энэ нь Монголбанкны судалгааны ажил олон улсын жишигт нийцэж буйг илтгэх болов уу.

СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН ТОЙМ


(2020 оны 02 дугаар сар)

1. Мөнгөний үзүүлэлт

Зураг 1.1. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн бүтэц (эх үүсвэр талаас)



Зураг 1.2 Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн бүтэц (байршуулалт талаас)




- M2 мөнгөний жилийн өсөлт 4.6%-д хүрч, нийт дүнгээр 20.5 их наяд төгрөг болов.

M2 мөнгөний жилийн өсөлтийн 3.4 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, 3.1 нэгж хувийг гадаад валютын хадгаламж, 0.6 нэгж хувийг төгрөгийн харилцах, -1.8 нэгж хувийг гадаад валютын харилцах, -0.7 нэгж хувийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө бүрдүүлсэн байна.


- M2 мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас нь авч үзвэл Төв банк болон хадгаламжийн байгууллагуудын дотоод цэвэр актив (ДЦА)-ын дүн 17.3 их наяд төгрөг, гадаад цэвэр актив (ГЦА)-ын дүн 3.2 их наяд төгрөгтэй тус тус тэнцэж байна.

2. Зээл

Зураг 2.1. Зээлийн үлдэгдлийн жилийн өсөлт, сектороор



Зураг 2.2. Зээл, зээлийн чанар



- Нийт зээл 17.9 их наяд төгрөг (төгрөгийн зээл 15.9 их наяд, гадаад валютын зээл 1.9 их наяд төгрөг)
- Хэвийн зээл өмнөх сараас 0.8%-иар
- Зээлийн үлдэгдэл өмнөх сараас 0.1%-иар тус тус буурч,
- Хугацаа хэтэрсэн зээл өмнөх сараас 12.4%-иар
- Чанаргүй зээл өмнөх сараас 0.6%-иар тус тус өссөн байна.

3. Ипотекийн зээл

Зураг 3.1. Тайлант сард олгосон ипотекийн зээл



Тайлант сард банкууд **634** зээлдэгчид **44.0** тэрбум ₮-ийн ипотекийн зээл шинээр олгосноос **42.6%** нь хөтөлбөрийн, **57.4%** нь банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл байв.


Зураг 3.2. Тухайн сард олгосон ипотекийн зээлийн хүү



Шинээр олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх жилээс **1.0** нэгж хувиар буурчээ.

4. Хүү

Зураг 4.1. Шинээр татсан хадгаламжийн хүү




- Иргэдээ татсан ₮-ийн хадгаламжийн ЖДХ **10.9%**, хувийн байгууллагаас татсан ₮-ийн хадгаламжийн ЖДХ **10.5%** байна.
- Иргэдэд шинээр олгосон ₮-ийн зээлийн ЖДХ **17.8%**, хувийн байгууллагад олгосон ₮-ийн зээлийн ЖДХ **16.3%** байна.

Зураг 4.2 . Шинээр олгосон зээл, хүү




5.1. Төлбөрийн тэнцлийн статистик, 2019 оны IV улирал /урьдчилсан/




ИНФЛЯЦИЙН ХҮЛЭЭЛТИЙН ТҮҮВЭР СУДАЛГАА

Зураг 6.1. Инфляцийн хүлээлт



Зураг 6.2. Инфляцийн хүлээлтийн тархалт



- Олон улсын туршлагад тулгуурлан иргэд, ААН болон шинжээчдийн инфляцийн хүлээлтийг улирал бүр тооцдог. 2020 оны I улиралд явуулсан судалгаагаар иргэд инфляцийг 2021 оны I улиралд **5.6%**, ААН-үүд **4.4%**, шинжээчид **7.8%**-тай байхаар хүлээж байна.

- Судалгаанд хамрагдсан иргэдийн **57%**, бизнес эрхлэгчдийн **50%** нь 2021 оны I улиралд инфляцийн түвшинг зорилтот түвшин болох **8%**-аас бага байна гэж үзсэн.

Эх сурвалж: Инфляцийн хүлээлтийн түүвэр судалгаа 2020 оны 02 сар, Монголбанк

МӨНГӨН ТОНОГТОЙ ХЭТ ХУТГА

XX зууны дунд үе

Төв халх хийц

Жин: 641.2 гр

Хутга: 26.5 см

Хуй: 17 см, голч: 1.5 х 2.7 см

1994 оны 2 дугаар сарын 23-ны өдөр Монголбанкны Эрдэнэсийн санд иргэн С.Жалан-Аажав худалджээ.

Хэт хутга нь хүрэн модон бариул болон хуйтай. Хуйг мөнгөн бүслүүрээр тоноглохын хамт өлзий хээгээр чимэглэсэн ажээ. Бэл, хэтийг төв халх хийцийг илтгэх эвэр угалз хээгээр ухаж сийлбэрлэсэн ба хутганы гурив болон ган цохилуурт угалзарсан хээг нэвт ухаж цоолборложээ. Мөн хэтний тээгт нисэж буушуууг үүл цэцэгс дунд дүрсэлсэн уран хийцтэй.



Монголбанкны Эрдэнэсийн сангаас

ЯПОНД АЖИЛЛАСАН ӨДРҮҮД

/Аян замын тэмдэглэл/



Б.ЛХАГВАСҮРЭН

Монголбанкны Ерөнхийлөгч

Токио хотноо болох Олон Улсын Валютын Сан (ОУВС), Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАИКА)-ын Тавдугаар уулзалтад оролцохоор Нарита олон улсын нисэх онгоцны буудалд газардлаа. Хэдийгээр Японы цаг агаар биднийг очихоос өмнөх өдрүүдэд тогтворгүй байсан ч, хаврын сүүл сар мэт зөөлөн урь угтсан нь нэн тааламжтай байв.

Токио зуны 32-дугаар олимпийн наадамд бэлдээд тун завгүй, бүтээн байгуулалтууд нь ид өрнөж байна. Гэтэл Японы эдийн засаг тун тааруу байгаа. Америк-Хятадын худалдааны дайны нөлөө тус улсад томоохон цохилт болж, хөрөнгө оруулалтууд нь буурч, эдийн засаг нь сүүлийн таван жилд тохиогоогүй хамгийн муу түвшиндээ хүрч суларчээ.

Хэрэглээнийхээ татварыг нэмэгдүүлэх бодлогын арга хэмжээ нь ч үүнд давхар хүндрэл үүсгээд байгаа юм. Залгуулаад коронавирус тус улсад бүртгэгдсэн нь эрсдэлийг улам нэмэгдүүлэх төлөвтэй боллоо. Ийнхүү дэлхийн гурав дахь том эдийн засгийг олон улсын шинжээчид цаашид саарсан хэвээр байх төсөөллийг дэвшүүлсээр байна. Гэсэн ч их гүрэн дэлхийн нийтийн тогтвортой хөгжлийг хангахад идэвхтэй байр сууриа илэрхийлсэн хэвээр байна.

Зорьж ирсэн уулзалтдаа хоёрдугаар сарын 12-13-ны өдөр оролцлоо. Ази Номхон Далайн бүсийн орнуудын Сангийн сайд, Төв банкны ерөнхийлөгч нар мөн судлаач, шинжээчид оролцдог уг уулзалтад миний бие Сангийн сайд Ч.Хүрэлбаатарын хамтаар оролцсон юм. Энэ удаагийн хурал “Хөгжиж буй Ази:

Төсвийн зохистой удирдлагаар тогтвортой, хүртээмжтэй өсөлтөд хүрэх нь” хэмээх ерөнхий сэдвийн дор болж, “Тогтвортой хөгжлийн зорилтууд болон хүртээмжтэй өсөлтөд хүрэх нь”, “Хүртээмжтэй, тогтвортой өсөлтийг дэмжихийн зэрэгцээ төсвийн болон өрийн тогтвортой байдлыг хангах нь” гэсэн 2 дэд хэлэлцүүлгийн дор өрнөв.

Хурлын нэгдүгээр хэлэлцүүлэгт ОУВС-ийн Төсвийн арга хэмжээний газрын хэлтсийн орлогч захирал Мерседес Гарсиа-Эскрибано “Тогтвортой хөгжлийн зарим зорилтуудад хүрэхэд шаардлагатай зардал” сэдвээр илтгэл хэлэлцүүлж, Япон улсыг ОУВС-нд төлөөлөх гүйцэтгэх захирал Такужи Танака хэлэлцүүлгийг удирдсан юм. Энэ хэлэлцүүлэгт миний бие Шриланк улсын төлөөлөлтэй хамт оролцож, санал дүгнэлтээ хуваалцлаа.

Хүртээмжтэй, тогтвортой өсөлтийг хангахад эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдал, санхүүгийн хүртээмж нэн ач холбогдолтой. Монгол Улсаас хэрэгжүүлж буй бодлого үйл ажиллагааны хувьд тухайлбал, ОУВС-тай хэрэгжүүлж буй хөтөлбөр, түүний үр дүн болон цаашид хэрэгжүүлэх бодлогыг макро эдийн засаг, банк санхүүгийн систем, бүтцийн өөрчлөлтийн бодлогын хүрээнд хэрэгжүүлж байна.

Манай улсын макро эдийн засгийн тогтвортой байдал 2016 оны хүнд үетэй харьцуулахад үлэмж дээшилсэн болохыг эдийн засгийн өсөлт, гадаад өрийн төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, гадаад валютын нөөцийн хүрэлцээ, төсвийн алдагдал, төсвийн өр, санхүүгийн зах зээлийн сэргэлт зэргээр дүгнэж болох юм. Түүнчлэн, Монгол Улс анх удаа ногоон санхүүжилтийн “Таксаном”-ийг баталж, санхүүгийн зах зээлд нэвтрүүлсэн. Энэ бол манай улсаас тогтвортой хөгжлийн төлөө хэрэгжүүлж буй цаашдаа ч тууштай хэрэгжүүлэх шаардлагатай бодлого болохыг оролцогчид санал нэгтэй дүгнэж байсан юм.

Харин олон улсын түвшинд судлаачдын зүгээс боловсрол, эрүүл мэнд, цэвэр ус, зам, цахилгаан гэх мэт хөгжлийн үзүүлэлтэд ахиц дэвшил гарч байгаа боловч хөгжлийн өмнө томоохон сорилт тулгарсаар байгаа төдийгүй эрчимтэй хөгжиж буй зах зээлүүдийн хувьд 2030 он хүртэл тэдгээрийн ДНБ-ий 4.1%, бага орлоготой болон хөгжиж буй улс орнуудын хувьд ДНБ-ий 15.4%, нийлбэр дүнгээрээ 2.6 триллион ам.доллар буюу 2030 оны дэлхийн ДНБ-ий 2.5 хувьтай тэнцэх хэмжээний зардлын хэрэгцээ байгааг онцолсон юм. Энэхүү зардлыг санхүүжүүлэхэд бага орлоготой болон хөгжиж буй улсуудын хувьд дотоод эдийн засгийн татварын бололцоог дайчлаад ч хангалтгүй тул төсвийн зардлын үр ашигтай хуваарьлалт чухал гэж дүгнэж байна. Цаашид тогтвортой хөгжлийн зорилтод хүрэх, санхүүжилтийг бүрдүүлэхэд улс орнуудын хувьд Засгийн газар, хувийн хэвшил, донор болон олон улсын байгууллагуудын хамтын ажиллагаа чухлаар тавигдаж байна. Түүнчлэн илүү өгөөжтэй их хөрөнгө оруулалтыг хийж өсөлтийг түргэсгэх хэлэлцүүлгийн хүрээнд Засгийн газрын өр, алдагдлыг бууруулах замаар өөрчлөлтийг хэрэгжүүлэх орон зайг үүсгэхээс гадна хувийн сектор, энтерпренорийг дэмжих, хүндээ хөрөнгө оруулалт хийхийг санал болгож байна. Төсвийн хувьд реформ хийхэд иргэдийн амьжиргаанд учирч болох сөрөг нөлөөллийг бууруулахын тулд нийгмийн эмзэг хэсэгт чиглэсэн нийгмийн халамжийн сайн тогтолцоотой байх нь чухал болохыг мөн онцолж байгаа юм.

Хурлын хоёрдугаар хэлэлцүүлэгт Сангийн сайд Ч.Хүрэлбаатар оролцсон юм. Түүний оролцсон хэлэлцүүлэгт “Хүртээмжтэй, тогтвортой өсөлтийг дэмжихийн зэрэгцээ төсвийн болон өрийн тогтвортой байдлыг эрсдэлд оруулахгүй байх” тухай асуудлыг хэлэлцэж, Төрийн санхүүжилтийн удирдлага, шинэчлэлийн талаар Японы олон улсын хамтын ажиллагааны газрын захирал Кенсүке Цүжи, ОУВС-ийн бүсийн зөвлөх Холгер Ван Эден нар илтгэл танилцуулсан. Монгол Улсын Сангийн сайд Ч.Хүрэлбаатар хэлэлцүүлгийн үеэр сүүлийн жилүүдэд төсвийн тогтвортой байдлыг хангах, Засгийн газрын өрийн дарамтыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн бодлого, түүний үр дүнг хуваалцаж бусад чиглэлээр санал, солилцсон

юм. Энэ хэсэгт судлаачийн илтгэлд бага орлоготой улс орнуудын өрийн эмзэг байдал нэмэгдэж байгаа бөгөөд хүү нь өсч, хугацаа нь богиносох хандлагатай байгааг дурдаж байв. Түүнчлэн өрийн тоон мэдээллийн нэгдмэл, нээлттэй байдал, хүлээж болзошгүй өглөгт болгоомжтой анхааралтай хандах, дунд хугацааны төсвийн чадамжтай уялдуулан зардлыг эрэмбэлэх, өрийн тогтвортой байдлын шинжилгээнд анхаарах зэрэг нь чухал ажээ.

Эцэст нь дугуй ширээний дүгнэх хэлэлцүүлгийг ОУВС-ийн Ази, номхон далайн газрын захирал Чангионг Рий удирдаж, Афганистан, Филиппин, Лаос, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллагуудын төлөөллийн санал бодлыг сонссон юм. Ийнхүү ОУВС-аас Ази тивд хийж буй бүс нутгийн томоохон арга хэмжээ болох тогтвортой хөгжлийн зорилтод хүрэх, хүртээмжтэй тогтвортой өсөлтийг улс орнууд бий болгох, болон дэлхийн нийтийн өмнө тулгамдаж байгаа асуудлуудыг бүс нутгийн түвшинд авч хэлэлцсэнээр энэ удаагийн хурал өндөрлөлөө.

Дэлхий нийтийг онц байдал зарлахад хүргэсэн “COVID-19” 2020 оны эдийн засагт тааварлашгүй нөхцөл байдал тулгаж, улс орнууд бодлогын төлөвөө өөрчилж, үүссэн нөхцөл байдлыг даван туулахад чиглүүлж буй нь одоогоор тулгараад буй хүндхэн асуудал болоод байна.

Нартай дулаахан, бас үе үе бороо дусалж байсан Токио харин нутаг буцахын үед зэврүүн хуйсагнасан салхи нь жихүүдэс төрүүлж байв. Нарита руу очих замын хажуугаар зуны олимпод зориулсан барилга байгууламжийн ажил өрнөн буй нь жирэлзэн харагдана.

*2020 оны 2 дугаар сарын 14
Токио хот*




ГАДААД ВАЛЮТЫН АЛБАН НӨӨЦИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭНҮҮД

Гадаад валютын албан нөөц бүрдүүлэх нь төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, улс орны богино хугацаат гадаад зээлийн төлбөрийг төлөх чадварыг хангах, үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн ханшийг тогтвортой байлгах, улс орныг бүхэлд нь хамарсан дотоод болон гадаад хүчин зүйлийн улмаас үүссэн эдийн засгийн хямралт байдлаас түргэн хугацаанд зардал багатай гарах зэрэгт ач холбогдолтой. Иймд нөөцийг хангалттай түвшинд байлгах шаардлагатай байдаг.

Харин манай улсын түүхэнд цэвэр нөөц хасах утга руу орж, нийт нөөц хамгийн доод түвшинд хүрч унасан тохиолдол 2014-2016 онд болсон нь 1 тэрбум гаруй ам.долларт хүрч буурсан явдал байлаа.

График: Гадаад валютын албан нөөцийн үзүүлэлт 2013-2019 он



Үүний гол шалтгаан нь Засгийн газраас гадаад зах зээлээс татсан 1.5 тэрбум ам.долларын санхүүжилтээс бүрдсэн 4.1 тэрбум ам.долларын нөөцийг интервенц болон уламжлалт бус мөнгөний бодлогын арга хэмжээний нөлөөгөөр ашигласан нь 2014-2016 онд эргэн 1 гаруй тэрбум ам.долларын түвшинд хүрч буурсан явдал юм.

Иймд Монголбанк гадаад валютын нөөцийг өсгөх, хамгаалах зорилгоор сүүлийн жилүүдэд дараах бодлогын шинжтэй арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлээд байна. Үүнд:

- Төсвийн шинж чанартай, уламжлалт бус мөнгөний бодлогын хэрэгслийг бүрэн халсан. Энэ тухай Төв банкны тухай хуульд нарийвчлан тусгаж, холбогдох өөрчлөлтийг оруулсан;
- Засгийн газартай хамтран ажиллаж, ОУВС-ийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт хамрагдсан. Улмаар ОУВС болон донор орнуудын санхүүжилтийг татсан;

- Засгийн газар олон улсын зах зээлээс санхүүжилт татах зорилгоор гадаад бонд гаргах тухай бүрд Монголбанкнаас дэмжиж, хамтран ажилласан;
- Алтны худалдан авалтыг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой ажлуудыг гүйцэтгэсний үр дүнд алт худалдан авалтын хэмжээг 2018 онд 21.9 тонн буюу хамгийн дээд түвшинд хүргэсэн;
- Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн валютын орлогыг Монголбанк худалдан авч эхэлсэн.

Эдгээр бодлогын хүчин зүйлсийн нөлөөгөөр гадаад валютын нөөц 2019 онд 4,348 сая ам.доллар буюу хамгийн өндөр түвшинд хүрч өсөөд байна.



ХОЁРДУГААР САРД 952 КГ ҮНЭТ МЕТАЛЛ ХУДАЛДАН АВЛАА

Монголбанк 2020 оны эхний хоёр сарын байдлаар нийт 4.3 тн үнэт металл худалдан авч, үүнээс 2020 оны 2 дугаар сард 952 кг үнэт металл худалдан авлаа. Энэ нь өмнөх оны мөн үед 96 кг үнэт металл худалдан авч байснаас 856 кг-аар өссөн үзүүлэлттэй байна. 2020 оны 2 дугаар сард Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс 16 кг, Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбар 18 кг үнэт металл тус тус худалдан авсан байна. Монголбанкны 1 грамм алт худалдан авах дундаж үнэ 2020 оны 2 дугаар сард 140,292.94 төгрөг байлаа.



График 1. 2018-2020 онд Монголбанкны худалдан авсан үнэт металлын сарын мэдээ (кг)




График 2. 1990-2020 онд Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ (тонн)



График 3. 2020 оны 2 дугаар сард Монголбанкны алт худалдан авсан үнэ (төгрөг/грамм)

ВАЛЮТ АРИЛЖААНЫ ЦАХИМ ТАЛБАРЫН ТОЙМ

Банк хоорондын валют арилжааны цахим талбарыг 2017/4/10-нд нэвтрүүлсэнээс хойш 2020/02/21-ний хооронд 1,976.7 сая ам.долларын болон 113.4 сая юанийн нийт 1415 удаагийн арилжаа БХВАЦТ-т хийгдээд байна.



А.АНАНД: МАКРО ЗОХИСТОЙ БОДЛОГЫГ ЗӨВХӨН ХЯЗГААРЛАХ ЗОРИЛГОТой ГЭЖ ОЙЛГОЖ БОЛОХГҮЙ



Монголбанкны МБГ-ын Макро зохистой бодлогын хэлтсийн захирал А.Анандтай ярилцлаа.

- Таны хувьд Монголбанкинд шинээр байгуулагдсан Макро зохистой бодлогын хэлтсийг удирдаж байна. Тэгэхээр хэлтсийн тань үйл ажиллагааны гол чиг үүрэг, өдөр тутмын ажлыг товчхон танилцуулна уу.

Санхүүгийн тогтвортой байдлыг хангахгүйгээр макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах боломжгүй болохыг 2008 оны дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал тод харуулсан байдаг. Тэр үеэс хойш Төв банкууд нийт санхүүгийн системийн тогтвортой байдалд анхаарал хандуулах нь эрс нэмэгдэж, санхүүгийн системд үүсч болзошгүй эрсдэлийг хязгаарлах, санхүүгийн системийн дархлааг бэхжүүлэх, нэгэнт эрсдэл бий болсон тохиолдолд хор хохирол багатайгаар даван туулахад макро зохистой бодлого чухал ач холбогдолтойг хүлээн зөвшөөрч, санхүүгийн тогтвортой байдлыг хангах институцийн тогтолцоог бэхжүүлэхэд ихээхэн анхаарч байна. Энэ жишгийн дагуу 2018 онд Төв Банкны тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсноор Монголбанк макро зохистой бодлого хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн. Улмаар санхүүгийн системийн тогтвортой

байдалд дүн шинжилгээ хийж эрсдэлийг тодорхойлох, тухайн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах зорилгоор макро зохистой бодлогыг боловсруулах үндсэн чиг үүрэг бүхий хэлтсийг 2019 онд байгуулсан. Одоогийн байдлаар санхүүгийн системийн эрсдэлийн шинжилгээ хийх арга техникийг хөгжүүлэх, макро зохистой бодлогын оновчтой институцийн тогтолцоог бүрдүүлэх ажлуудад гол анхаарлаа хандуулж байна.

- Макро зохистой бодлого гэдгийг энгийнээр томъёолбол, хэрхэн тайлбарлаж болох вэ? Монголбанк яагаад мөнгөний бодлогын арга хэрэгслүүдээс гадна, макро зохистой бодлогод анхаарах болов?

Энгийн үгээр хэлбэл хямрал боллоо гэхэд санхүүгийн байгууллагууд зуучлагчийнхаа үүргийг хэвийн явуулж байх, аливаа төлбөр тооцоог саадгүйгээр хийх чадвартай байх, үүнд эртнээс бэлтгэх гэж ойлгож болох байх. Санхүүгийн системд арилжааны банкуудаас гадна олон оролцогч байгууллагууд бий. Тиймээс санхүүгийн зохицуулагч байгууллагуудын хамтын ажиллагаа,

бодлогын уялдаа чухал үүрэгтэй.

Мөнгөний бодлогын арга хэрэгслүүдийг ашиглан санхүүгийн зах зээлийн зарим хэсэгт үүссэн эрсдэлийг хязгаарлах нь зардал өндөртэй, үр дүн муутай байх талтай байдаг. Жишээлбэл, эдийн засгийн идэвхжлийг дагасан өрхийн зээлийн хэт өсөлтийг сааруулах зорилгоор бодлогын хүүг өсгөх нь дотоодын хөрөнгө оруулалтыг хумих, зээлдэгчдэд хүүний дарамтыг бий болгож, зээл чанаргүйдэх эрсдэлийг нэмэгдүүлэх, богино хугацааны ашиг хайсан хөрөнгийн дотогшлох урсгалыг дэмжиж, ханшийн савлагаа үүсгэх зэрэг сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. Энэ үед эдгээр эрсдэлийг хязгаарлах зорилгоор макро зохистой бодлогын арга хэрэгслүүдийг ашиглах нь үр дүнтэй шийдэл байх боломжтой.

- Монголбанк Макро зохистой бодлогын зохицуулалтуудыг өнгөрсөн оноос хэрэгжүүлж эхэлсэн. Хэрэглээний зээлийг хязгаарлах, валютын зээлийн эрсдэлийн жинг нэмэгдүүлэх зэрэг шийдвэрүүд гаргасан нь өнөөдөр хэр үр дүнгээ өгч байна вэ?

Бусад улсын туршлагаас харахад өрхийн өрийн түвшин нэмэгдэх нь богино хугацаанд хэрэглээгээр дамжин эдийн засгийн өсөлтийг дэмжих боловч дунд болон урт хугацаандаа эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлдэг байна. Мөн Монголбанкнаас 2017 онд гүйцэтгэсэн судалгааны үр дүнгээр Монголд өрхийн өрийн түвшин аль хэдийн эдийн засагт сөрөг нөлөө үзүүлэх түвшинд хүрсэн болохыг тодорхойлсон. Ийм учраас Мөнгөний бодлогын хорооны ээлжит хурлуудаар өрхийн өрийн дарамтыг бууруулах, улмаар санхүүгийн системд үүсч болзошгүй хүндрэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор банкнаас олгох хэрэглээний зээлийн хувьд өр, орлогын харьцаа болон хугацааны хязгаарлалт тогтоож мөрдүүлж байна. Уг бодлого хэрэгжиж эхэлснээр 2018 онд жилийн 55 хувьд хүрээд байсан хэрэглээний зээлийн өсөлт саарч, 2020 оны 1 дүгээр сарын байдлаар 5.2 их наяд гаруй төгрөгт хүрсэн байгаа нь жилийн өмнөхөөс 7.7 хувиар буурсан үзүүлэлт байна. Үүнээс гадна

бизнесийн зээл олголт нэмэгдэх, хэрэглээний зээлийн хүү буурах, хэрэглээний зээлээр санхүүжигдэж буй импорт буурч байгаа эерэг үр дүнгүүд гарч байна.

Мөн гадаад валютын орлогогүй, ханшийн эрсдэлтэй зээлдэгч нарт олгосон гадаад валютын зээлийн эрсдэлийн жинг 150 хувьд хүргэн нэмэгдүүлэх бодлогын арга хэмжээ авсан. Ингэснээр ханшийн эрсдэлтэй иргэд, ААН-үүдийн гадаад валютын зээлийн үлдэгдэл хумигдаж, зээлийн долларжилт буурч байна.

- Макро зохистой бодлого мөнгөний бодлогын шийдвэрүүдтэй хосолсноор үр дүнгийн хувьд илүү сайн нөлөө үзүүлэх байх. Одоогоор Монголбанкны бодлогын хүү 10 хувьтай байна. Дээр нь макро зохистой бодлогын шийдвэрүүдээр иргэдийн хэрэглээний зээлийг хязгаарласан бодлого хэрэгжиж байна гэхээр эдийн засгийн ийм орчныг юу гэж дүгнэхээр байна вэ?

Мөнгөний бодлогын дам нөлөө нь санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй үед макро зохистой бодлогоор эрсдэлийг хязгаарлах талаар түрүүн хэлсэн. Макро зохистой бодлого болон мөнгөний бодлогын зорилтууд хоорондоо ялгаатай байдаг. Гэхдээ макро эдийн засаг, санхүүгийн системийн нөхцөл байдлаас шалтгаалан эдгээр бодлогууд харилцан бие биенээ нөхөх байдлаар хэрэгжиж явдаг. Өнөөгийн нөхцөл байдлыг харгалзан үзвэл хэрэглээний зээлийг хязгаарлах макро зохистой бодлого нь нэг талаас өрхийн өрийн дарамтыг бууруулж, санхүүгийн системийн тогтвортой байдлыг хамгаалахад эерэг нөлөө үзүүлж буй бол нөгөө талаас 2019 оны эхний улиралд нэмэгдүүлсэн цалин, тэтгэврийн хэмжээг даган бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтийг хязгаарлах, инфляцийг зорилтот түвшинд хадгалахад дэмжлэг үзүүллээ. Өөрөөр хэлбэл, одоогийн баримталж буй макро зохистой бодлого нь Төв банкны үндсэн зорилготой нийцтэй байна гэж хэлж болохоор байна.

- 2020 оны эдийн засгийн төлөв, гадаад дотоод эдийн засгийн нөхцөл байдал, хүлээлт аль чиглэлд байна вэ?

Сүүлийн үед дэлхий дахины анхаарлын төвд ороод байгаа БНХАУ-д илэрсэн шинэ төрлийн коронавирусууд шалтгаалан БНХАУ-д онцгой дэглэм тогтоож, томоохон үйлдвэрүүдийн үйл ажиллагааг зогсоож, хөл хорио тогтоогоод байгаа. Энэ нь мэдээж гол түүхий эдүүдийн үнээр дамжин манай экспортын орлогыг бууруулах нөлөөтэй. Мөн нөхцөл байдалтай холбоотойгоор УОК хуралдаж тодорхой хугацаанд нүүрсний экспорт, улс хоорондын зорчигч тээвэрүүдийг зогсоож, дотоодын зарим үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагааг хязгаарлах шийдвэрүүдийг гаргасан. Юун түрүүнд богино хугацаандаа экспортын орлого тасалдаж, тээвэр, аялал жуулчлал болон үйлчилгээний салбаруудад үйл ажиллагаа явуулж буй зарим ААН-үүдэд сөргөөр нөлөөлөхөөр байна. Олон улсын байгууллагууд эхнээсээ өсөлтийн төсөөллөө өөрчлөөд эхэлсэн ч энэхүү вирусын тархалт цаашид хэр удаан үргэлжлэхийг хэлэхэд арай эрт байна.


- Макро зохистой бодлогын хүрээнд өнөөгийн байдлаар зөвхөн хязгаарлах чиглэлийн бодлогын зохицуулалтууд хэрэгжиж байна. Тэгэхээр энэ нь зөвхөн хязгаарлах чиглэлтэй л бодлогууд гэсэн үг үү. Эдийн засгийн өсөлтийг дэмжих, тэтгэх чиглэлд макро бодлогууд хэрэгжих боломжтой юу, ямар нөхцөлд?

Макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх үндсэн зорилго нь нэгдүгээрт, санхүүгийн тогтвортой байдлыг хангах; хоёрдугаарт, санхүүгийн системийн дархлааг бэхжүүлэх; гуравдугаарт, системийн эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд оршино. Тиймээс өрхийн өрийн дарамтыг бууруулах зорилгоор хэрэгжүүлж буй макро зохистой бодлогыг зөвхөн хязгаарлах чиглэлийн бодлого гэвэл өрөөсгөл ойлголт болно. Тус бодлого нь санхүүгийн системд хуримтлагдаж болзошгүй эрсдэлийг хязгаарлахаас гадна эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийг дэмжих, зээлдэгчийг хамгаалах зорилготой арга хэмжээ. Тодруулбал, иргэдийн хэрэглээний зээлийг хязгаарласнаар банкны эх үүсвэр ажлын байрыг нэмэгдүүлэх, бодит эдийн засагт чухал нөлөө үзүүлэх бизнесийн

зээлийг дэмжихэд чиглэх юм. 2018 оны эхний улирлын байдлаар иргэдийн сарын дундаж нэрлэсэн цалин 998 мянган төгрөг, үүнээс нийгмийн даатгалын шимтгэл, ХХОАТ-ыг хасч тооцвол гарт олгох цалин 811 мянган төгрөгтэй тэнцэж байв. Тухайн үед амьжиргааны баталгаажих доод түвшин 198 мянган төгрөгтэй тэнцэж байсан бөгөөд энэ нь 811 мянган төгрөгийн 24.5 хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл, иргэд цалингийн зээл авах үед зээлийн сарын төлбөр нь гарт олгох цалингийн 75.5 хувиас хэтэрсэн тохиолдолд амьжиргааны доод зардлыг хангах боломжгүйд хүрч байсан. Хэрэв энэ тооцоог 4 ам бүлтэй, 2 хүний цалингийн орлоготой өрхийн хувьд хийвэл зээлийн сарын төлбөр нь өрхийн орлогын 49 хувиас хэтэрвэл өдөр тутмын зайлшгүй хэрэглээгээ санхүүжүүлэх боломжгүй болж байв. Иймд өр, орлогын харьцааны хязгаарлалт тогтоосноор зээлдэгч нь амьжиргааны наад захын хэрэгцээгээ хангах орлогыг өөртөө авч үлдэх боломжийг бүрдүүлж, зээлдэгчийг хамгаалсан шийдвэр болсон юм. Түүнчлэн хэрэглээний зээлийг хязгаарлах бодлого нь нийт эрэлтийг сааруулан хэрэглээг бууруулж, бодит эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. Гэвч 2019 оны 3 дугаар улирлын тоон мэдээллээс үзэхэд нийт өрхийн хэрэглээ өмнөх оны мөн үеэс 12.4 хувиар өссөн байна.

Ярилцсанд баярлалаа.

ТҮҮХИЙ ЭДИЙН ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ (АМ. ДОЛЛАРААР, 28/II ӨДРИЙН БАЙДЛААР)



“КОВИД-19” ВИРУСИЙН ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

Венесуэль улсад байрлах Оросын Роснефть ХК-ийн нэгжид АНУ хориг тогтоов. ОХУ-ыг Венесуэлийн төрийн өмчит газрын тосны компани болон ерөнхийлөгч Николас Мадуротой холбоотой ажиллаж байна гэсэн үндэслэлээр энэхүү хоригийг тогтоожээ. Венесуэль улс 2020 оны 1 дүгээр сарын байдлаар дэлхийн газрын тосны 0.9 хувийг, ОПЕК-ийн 3 хувийг нийлүүлсэн байна.

Нөгөө талаас Ливи улсад өрнөж буй бослого улам даамжирч тус улсын газрын тосны олборлолтод саад болж байна. Ердийн үед Ливи улс өдрийн 1.2 сая баррель тос экспортолдог байсан бол 2020 оны 1 дүгээр сард өдрийн 900,000 баррель болтлоо буурчээ. Ливи улс дэлхийн газрын тосны үйлдвэрлэлийн 1 хувийг, ОПЕК-ийн экспортын 3.2 хувийг бүрдүүлдэг.

Венесуэль, Ливи хоёр улсын экспорт тасалдах аюул үүсч байгаа нь нийлүүлэлт буурахад нөлөөлж коронавирусээс үүдсэн эрэлтийн бууралтыг тэнцвэржүүлж газрын тосны ханш эргэн өсөөд байна.

Үүнээс гадна Хятад улсад шинээр коронавирусийн халдвар авсан хүмүүсийн тоо 394 бүртгэгдсэн нь өмнөх долоо хоногийн мөн үетэй харьцуулахад 5 дахин буурсан тоо юм. Мөн Хятад улс вирустэй тэмцэх бодлогоо шинэчилснээ ч мэдэгдсэн бөгөөд энэхүү үйл явдал нь Хятадын зүгээс вирустэй тэмцэх бодлого үр дүнгээ өгч байгааг илтгэж, эдийн засаг сэргэх найдвар өсч, түүхий эдийн үнэ сэргэлээ.

Ковид-19 вирусийн тархалт нэмэгдсэнээр олон улсын хувьцаануудын үнэ сүүлийн хоёр жилийн хугацаанд хамгийн доод түвшинд хүрэв.

Хятадаас гадуурх Ковид-19 вирусийн шинэ тохиолдлууд нэмэгдсэн нь дэлхийн зах зээл дээрх хувьцаануудын үнэ сүүлийн 2 жилийн хугацаан дахь хамгийн муу түвшинд хүрэхэд нөлөөлж дэлхийн эдийн засгийн өсөлт саарах вий гэсэн болгоомжлолыг төрүүлэв.

Ази, Европын хувьцааны зах зээл 2018 оны 2 дугаар сард эхэлсэн худалдааны дайнаас хойшхи хамгийн том уналттай тулгараад

байгаа бөгөөд FTSE All World индекс 3 хувиар буурлаа.

Эрчим хүчний хувьцааны үнэ буурсан нь газрын тосны үнийн бууралт болон технологийн компаниудын хувьцааны үнэ унаснаас үүдэлтэй байна. Олон улсын тээврийн компаниудын хувьцааны үнэ мөн адил уналтанд ороод байгаа бөгөөд АНУ-ын агаарын тээврийн компаниуд болох Delta болон FedEx-ийн хувьцааны үнэ бүгд 5-аас дээш хувиар буурсан бол АНУ-ын банкуудын KBW индекс 3.6 хувиар буурсан нь 2019 оны 8 дугаар сараас хойш хамгийн өндөр уналт болжээ.

АНУ-ын ерөнхийлөгч Дональд Трамп твиттер хуудсаараа “коронавирусийг АНУ хяналтандаа оруулсан” гэж мэдэгдсэн бөгөөд “Хөрөнгийн зах зээлийн төлөв байдал надад маш сайнаар харагдаж эхэллээ” хэмээн нэмж хэлжээ.

Зураг 6. АНУ-ын хувьцааны индекс



Их Британийн хувьцааны үнэ сүүлийн 5 жилийн хугацаан дахь хамгийн өндөр бууралттай байсан бол Италийн MIB индекс 5.4 хувиар унасан нь 2016 оноос хойшхи хамгийн муу үзүүлэлт байв. Европ тив даяар Stoxx 600 3.8 хувиар буурсан бол Их Британийн FTSE 100 индекс 3.3 хувиар буурав. Коронавирусийн тархалт агаарын тээврийн компаниуд болон аялал жуулчлалын операторуудад хүнд цохилт болсон бөгөөд Европын агаарын тээврийн томоохон компаниуд болох EasyJet болон Ryanair компаниудын хувьцааны үнэ 17, 13 хувиар тус тус унав.



БНХАУ-ЫН ЭДИЙН ЗАСАГ ХҮЧТЭЙ СААРСАН ШИГЭЭ ХҮЧТЭЙ СЭРГЭНЭ

ОУВС-аас дэлхийн эдийн засгийн төлөвийн тайланд БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийг 2020 онд 6.0%, 2021 онд 5.9% байхаар төсөөлөөд байгаа билээ. Олон улсын худалдааны тэргүүлэх тоглогч, бусад улсын эдийн засагт шууд нөлөөлж чадахуйц тус улсад шинэ төрлийн коронавирус гарч, дэгдэлт нь буурахгүй, халдвар авсан хүмүүсийн тоо өссөөр байгаа нь эдийн засгийн өсөлтийнх нь төлөвийг бууруулах хандлагатай байна. БНХАУ-ын эдийн засгийн өсөлт үүнээс өмнө хэрхэн тогтвортой байсан, өдгөө ямар өөрчлөлт бий болоод байгаа, мөн цаашдын хандлага нь хаашаа чиглэж буй талаар энд онцоллоо.

БНХАУ-ЫН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙН НУУЦ

Дөч орчим жилийн тэртээ Дэн Сяопины удирдлага доор БНХАУ эдийн засгийн реформыг эхлүүлсний үр дүнд 1990 оноос хойш эдийн засаг нь тогтмол 6%-иас дээш өсөлтийг үзүүлсээр ирсэн юм. Энэ өсөлтийн нууц юу байв? Хариулт нь: Маш олон хүчин зүйлсийн нийлбэр боловч гол суурь нь эдийн засгийг либералчилж, дасан зохицох чадвартай болгосонд байгаа юм. Эдийн засгийн хөгжил, түүний явц нь маш ярвигтай, бартаа нугачаатай байдаг. Улс орон бүр

түүнд зохицуулж, бодлогоо шинэчилж байх шаардлага тулгардаг. Гэсэн ч хямралын гол шалтгаануудын үндэс нь ихэвчлэн бүтцийн болон бодлогын өөрчлөлтийг цаг тухайд нь хийж түүндээ дасаж чадаагүйгээс болдог. Нөгөөтэйгүүр, хөгжил буурай орнуудын эдийн засаг эрчимжиж дунд ангилалд орох үед тэндээ гацдагийг “middle income trap” гэдэг. Латин Америкийн болон Өмнөд Азийн олон орнууд нэгэнтээ өндөр өсөлтөөрөө гайхагдаж байсан ч өдгөө ийм гацаанд орчихоод байгаа юм. Харин БНХАУ-ын хувьд хөгжлийн стратегидаа тогтмол тохируулга хийж, институцийн түвшинд томоохон шинэчлэлүүдийг хэрэгжүүлж ирсэн нь тус улсын эдийн засгийн өсөлт сүүлийн 29 жилд дунджаар 9.5% өсч, дэлхийн 2 дахь хүчтэй эдийн засаг болоход хүргэжээ.

Хятадын эдийн засаг 1970-аад оны үед газар тариалангаас голлон хамаарч байсан бол төвлөрлөөс зайлсхийж, аж үйлдвэрлэл, технологийн секторуудад чиглэж эхэлсэн. Мөн үед иргэдийнх нь амьдралын хэв маяг өөрчлөгдөж, газар тариаланд тулгуурласан тосгонуудаас шинэ хотууд бий болж, иргэдийн боловсролын түвшин огцом дээшилсэн байв. Эдийн засагт өрсөлдөх чадвар, үр бүтээмжтэй байдал гэдэг бол хөгжилд хүрэх чухал хэмжүүр байдаг шиг

Хятадын бодлого нь өөрсдийн давуу талаа тодорхойлж, түүнийгээ дайчилж чадсанд юм. Мэдээж эдийн засгийн хөдөлгөх хүч нь нэг талаас эрэлт, нөгөө талаас ажиллах хүч тул хүн амын хувьд тус улсад энэ давуу байдал аль хэдийн бий болоод байлаа. Энэ нөхцөл байдалдаа боловсролын реформ хийж урт хугацаанд мэргэшсэн боловсон хүчнийг бий болгож чадав. Цаашлаад, төвлөрсөн улс төр, нийгмийн байгуулалтын тогтолцоо 1.4 тэрбум хүн амыг зохион байгуулалтад оруулахад маш их дэмжлэг болсон гэж үздэг. Төв засгийн газраас нь гадна орон нутгийн засгийн газар нь өндөр эрх мэдэлтэй байдгийн хувьд нөөц бололцоогоороо дамжуулж, инноваци бүхий жижиг дунд үйлдвэрлэлийг тэтгэж иржээ. Сүүлийн үеийн технологийн салбарт хүч түрж орж ирж байгаа компаниуд бүгд энэ боломжийг ашигласан ба өдгөө эдийн засагтаа чухал тоглогч болж байна. Түүнчлэн, эдийн засгийн чөлөөт бүсүүдийг бий болгож, чиглэл бүрээр хөгжүүлсэн нь урт хугацааны бодлогын үр дүн юм. Тухайлбал, Хонгконгийг дагуулж Шинженийг эдийн засгийн чөлөөт бүс болгосон нь өдгөө гадаадын хөрөнгө оруулалтыг татсан санхүү, технологийн төв болсон бол Макао дагуулж Жухайг хөгжүүлсэн нь олон улсын худалдааны зангилаан дээр орших бизнесийн аялал жуулчлалын бүс болгожээ.

ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БОЛОН ТҮҮНД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ

Өнгөрсөн оны статистик гарч байгаа энэ үед БНХАУ-ын 2019 оны өсөлт 6.1% буюу сүүлийн 29 жилийн хамгийн сул түвшинд хүрсэн нь АНУ-тай өрнүүлсэн худалдааны маргааны нөлөө юм. Хоёр жилийн турш хэлэлцэж, мэтгэлцсэн энэ хугацаанд олон компани үйлдвэрлэлийн хямд өртөг бүхий Индонез, Вьетнам зэрэг улсууд руу нүүснээр 44%-ийн өсөлттэй байсан худалдааны тэнцэл нь -1.1% болж огцом буурчээ. Худалдааны маргаан эдгээр болон бусад олон сөрөг нөлөөллийг БНХАУ-ын эдийн засагт үзүүлж, тодорхой бус байдлыг бий болгоод байсан ч он гарсаар харьцангуй эерэг дүр зургийг бий болголоо. 2019 оны нэгдүгээр сард хоёр тал эхний шатны хэлэлцээрт хүрсэн нь чухал үйл явдал болов. Худалдааны маргааны үр дүнд АНУ нь БНХАУ-ын бараа бүтээгдэхүүнд 550 тэрбум ам.доллартай дүйцэхүйц тарифыг ногдуулсан бол БНХАУ-ын талаас нийт 185 тэрбум ам.долларын тариф тавьсан юм. 1-р шатны хэлэлцээрийн үр дүнд АНУ-ын зүгээс 15%-ийн тарифыг хагасалж 7.5% болгосон бол БНХАУ тарифыг 5% болон 2.5% болгож тус тус бууруулсан. Энэ нь 200 тэрбум орчим ам.доллараар хэмжигдэх үзүүлэлт билээ.

БНХАУ-ЫН ӨСӨЛТӨД ГАРАХ ӨӨРЧЛӨЛТ

Морган Стэнлигийн шинжээчдийн зүгээс шинэ коронавирусын дэгдэлтийн улмаас БНХАУ-ын эдийн засагт гарах сөрөг өөрчлөлтийн далайц нь үйлдвэрлэл, бүтээмж хэр удаан хугацаанд тасалдахаас хамаарна гэж үзэж байна. Ингэхдээ 3 өөр хувилбараар өсөлт хэрхэн өөрчлөгдөхийг тооцжээ.

Хувилбар	2020 он 1-р улирал	2020 он 1-р хагас	2020 он 2-р хагас	Жилийн эцэс
Вирусийн тархалт 2/3 сард оргилдоо хүрч, Хубэй мужаас бусад бүсэд хурдацтай сэргэх	5.3%	5.6%	6.2%	5.9%
Вирусийн тархалт 2/3 сард оргилдоо хүрч, Хубэй мужаас бусад бүсэд алгуур сэргэх	4.2%	5.0%	6.3%	5.7%
3 сард хугарал бий болох ч вирусийн тархалт 4 сард оргилдоо хүрэх	3.5%	4.6%	6.5%	5.6%

Эх сурвалж: NBS, Morgan Stanley Research

Хэдийгээр худалдааны эхний хэлэлцээрт хүрээд байгаа ч цаашид тохиролцох асуудлууд оршсоор байна. Өөрөөр хэлбэл тодорхой бус байдал хадгалагдсаар байгаа ба 2020 оны төгсгөлд хийгдэж болох дараагийн шатны хэлэлцээр хойшлох, эсвэл бүр асуудал дахин хурцдахыг үгүйсгэх аргагүй.

БНХАУ-ын хувьд эдийн засгийн төлөвт гэрэл гэгээ туссан хэдий ч өөр нэгэн томоохон асуудал тулгараад байгаа нь шинэ төрлийн коронавирусийн дэгдэлт юм. Тус улсад гахайн мялзан өвчин асуудал дагуулсан хэвээр атал дээр нь COVID-19 вирусийн цар тахал нэмэгдлээ. Бүс нутаг, хот суурин газруудад хөл хорио тогтоож, аж үйлдвэрүүд зогсолт хийгээд байгаа нь нийлүүлэлт болон эрэлтийн аль аль талд огцом хязгаарлалт болоод байна. Роетерсийн эдийн засагчдын асуулгын үр дүнд БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 1-р улиралд 4.5%-д хүрч өмнөх улирлаас 1.5%-иар буурах төсөөлөл гаргажээ. Цаашлаад Морган Стенлигийн зүгээс 1-р улирлын өсөлт хамгийн багадаа 3.5%-иар буурах эрсдэлтэй байна гэж мэдээллээ. Дэлхийн газрын тос, зэс, нүүрс зэрэг аж үйлдвэрийн бүтээгдэхүүнүүдээс авахуулаад үйлчилгээний салбарын эрэлт огцом буурч үр нөлөө нь бусад улсын эдийн засагт шууд нөлөөлөх хандлагатай байна.

Шинэ коронавирусийн эдийн засагт үзүүлэх бодит нөлөөллийг хараахан таамаглах боломжгүй байгаа боловч spillover effect буюу бусад улсуудад үзүүлэх нөлөөлөл нь энэ оны төгсгөл хүртэл үргэлжлэх таамагтай байна. Эдийн засаг хурдтайгаар саарч байгаа бодит байдлыг харгалзан үзэж цаашид хэрхэн сэргэх талаарх хандлагыг тодорхойлох шаардлага тулгардаг ба ингэхдээ V, U, L, W хэлбэртэйгээр

зурах боломжтой байдаг. Тухайлбал, эдийн засаг огцом буурч, доод цэгтээ хэсэг хугацааг өнгөрүүлсний дараа эргэж сэргэх юм бол U хэлбэрийн график зурагддаг бол эдийн засаг сэргэлт авахгүй доод түвшиндээ тогтворжвол L хэлбэрийн зураглал гардаг. Харин уналт, сэргэлт, тохируулга ээлжилбэл W хэлбэрийн муруй зурагдах болно. Эдийн засагчдын таамаглалаар шинэ коронавирусийн нөлөөллөөр БНХАУ-ын эдийн засгийн өсөлт огцом саарч байгаа үед цаашид сэргэх боломжийг V хэлбэртэй байхаар төсөөлж байна. Юу гэсэн үг вэ гэвэл, эдийн засгийн өсөлт огцом саарсан шигээ эргэж хүчтэй сэргэх боломжтой байгаа аж.

Ямартай ч 1-р улиралд бий болсон алдагдсан боломжийн өртгийг эргэж нөхөх аргагүй юм. Өөрөөр хэлбэл тус хугацаан дахь хэрэглээг дахин нөхөх боломжгүй. Ялангуяа, тус улсын үндэсний баяр цагаан сарын худалдан авалт, энэ үеэрх бизнесийн өсөлт огцом нэмэгддэг ч шинэ коронавирусийн дэгдэлт үүнд маш том тээг боллоо. Тиймээс нэгэнт энэ хугацаанд үүссэн эдийн засгийн алдагдлыг гүйцээх аргагүй тул БНХАУ-ын 2020 оны цаашдын төлөв буурах нь тодорхой болоод байна. Асуултын гол нь вирусийн халдварын оргил үе хэдэн сард тохиохоос хамаарч цаашдын төлөв тодорхойлогдоно. Морган Стэнлигийн зүгээс уг оргил үе 2-3 сард тохиож халдварын голомтоос гаднах бүсэд огцом сэргэвэл жилийн эцсийн өсөлт 5.9%, хэрэв 3-4 сард тохиож голомтоос гадуур аажуу сэргэвэл 5.7%, оргил үе нь 4 сард тохиовол 5.6% болж буурна гэсэн таамгийг дэвшүүлжээ.

Эх сурвалж:

<https://www.weforum.org/agenda/2014/12/whats-the-secret-of-chinas-growth/>

<https://www.bbc.com/news/business-51025464>

<https://www.reuters.com/article/us-china-health-economy-poll/chinese-economy-clobbered-by-coronavirus-but-set-to-recover-soon-reuters-poll-idUSKBN20801H>

<https://www.cnbc.com/2020/02/19/coronavirus-morgan-stanley-economic-forecasts-for-chinas-growth.html>

Монгол Ардын хувьсгалын 50, 60 жилийн ойд зориулан гаргасан 1 төгрөгийн зоос

Он: 1971, Метал: гуулийн хайлш,
Жин: 32 мм, 14.9 гр, голч: 32 мм
Нэрлэсэн үнэ: 1 төгрөг



НҮҮР ТАЛ:
Д.Сүхбаатарын морьтой хөшөөг товойлгон дүрсэлж, дээд талд нь "БНМАУ" гэж улсын нэрийг товчлон, хажуу талд нь "50 жил" гэж кирилл үсгээр бичсэн.



АР ТАЛ:
БНМАУ-ын төрийн сүлдний дээд талд улсын нэрийг хагас дугуйруулан, доод талд нь нэрлэсэн үнийг тус тус бичсэн.

Он: 1971, Метал: алт, 18.4 гр - мөнгө,
14.9 гр - гууль, Жин: 30.3 гр, голч: 32 мм,
Нэрлэсэн үнэ: 1 төгрөг



НҮҮР ТАЛ:
Д.Сүхбаатарын морьтой хөшөөг товойлгон дүрсэлж, дээд талд нь "БНМАУ" гэж улсын нэрийг товчлон, хажуу талд нь "50 жил" гэж кирилл үсгээр бичсэн.



АР ТАЛ:
БНМАУ-ын төрийн сүлдний дээд талд улсын нэрийг хагас дугуйруулан, доод талд нь нэрлэсэн үнийг тус тус бичсэн.

Он: 1981, Метал: гуулийн хайлш
Жин: 32 мм, 14.9 гр, голч: 32 мм
Нэрлэсэн үнэ: 1 төгрөг



НҮҮР ТАЛ:
Төв хэсэгт Жанжин Д.Сүхбаатарын хөшөө, зүүн талд нь "60 жил", дээд талд нь улсын нэрийг товчлон "БНМАУ" гэж кирилл үсгээр бичсэн.



АР ТАЛ:
Тариан түрүүний голд "60" гэж Араб тоогоор бичээд, дээд талд нь "Соёмбо" дүрсэлсэн.

НОРИХИКО КАТО: БАНКИЙГ ОЛОН НИЙТИЙН БОЛГОХ НЬ ХӨГЖЛИЙН ЭЕРЭГ БӨГӨӨД ЧУХАЛ ШАТ ЮМ

Норихико Като нь 1979-1981 онд Токиогийн их сургууль, 1986-1988 онд UCLA-Андерсон Их сургуулийг тус тус дүүргэсэн.

Ноён Норихико Като нь банкны салбарт 30 гаруй жил ажилласан арвин туршлагатай. Тэрээр ажлын гараагаа Bank of Tokyo (одоогийн MUF-G)-оос эхлүүлж, Токио, Нью Йорк, Амстердам, Бахрейнд байгууллагын банк, хүний нөөц, байгууллагын төлөвлөлт хариуцан удирдлагын бүх шатанд ажиллаж байсан. Мөн 2009-2016 онд Монголын банкны салбарт, тухайлбал Хаан Банканд Гүйцэтгэх захирлын орлогч болон Гүйцэтгэх захирлаар, Монголын Банкны холбоонд Дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байсан.

Голомт Банкны Гүйцэтгэх захирлаар томилогдохын өмнө ноён Като нь Камбожийн Сатапана банкны Гүйцэтгэх захирлаар ажиллан тус банкныг дижитал үйлчилгээгээр улсдаа тэргүүлэгч банк болгож чадсан байна.

Тэрээр 2019 оны 5 дугаар сараас эхлэн Голомт банкны Гүйцэтгэх захирлаар томилогдон ажиллаж байна.



Голомт банкны Гүйцэтгэх захирал Норихико Катотой ярилцлаа.

– Энэ жил Голомт банкны 25 жилийн ой тохиож байна. Үүний хүрээнд бодлогын түвшинд ямар ажлууд хийж, хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байгаа вэ?

Одоогоос 25 жилийн өмнө Голомт банк анх бизнесээ тэгээс эхлүүлж, үйл ажиллагааныхаа эхлэлийг тавьсан тэр цагаас хойш шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг харилцагчдадаа анхлан танилцуулагч, инновацлаг банк байхын төлөө тэмүүлсээр, зах зээлдээ тэргүүлэгч банк болжээ. MasterCard Worldwide, Visa International байгууллагын гишүүн болж, олон улсын төлбөрийн картуудыг хэрэглэгчдэдээ анхлан хүргэж байсан Голомт банк “Американ экспресс” төлбөрийн картыг Монголд Улсад мөн л анх удаа нэвтрүүлж, тус картыг хүлээн

авагч эрх бүхий цор ганц банк гэх статусаа хадгалсаар ирсэн. Бодлогын хүрээнд Голомт банкныг системийн ач холбогдолтой, зах зээлдээ нөлөө бүхий тоглогч гэж тодорхойлж байна. Бид зах зээлийн бүх сегментэд чиглэж ажиллахаас гадна урт хугацаанд бодит өгөөжийг бий болгохыг зорьж, Монгол Улсын эдийн засгийн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулж байгаадаа таатай байдаг.

– Танай банк цаашид ямар том амбиц, зорилттой байна вэ?

Голомт банк Монгол Улсын банкны системийн 20 орчим хувийг бүрдүүлдэг, системийн нөлөө бүхий банкаар нэрлэгдэж байна. Энэ бол томоохон байр суурь, нөгөө талаас томоохон үүрэг хариуцлага юм. Байгууллагын банк болон иргэд, жижиг дунд бизнес эрхлэгчдэд банкны үйлчилгээг шинэ технологийн дэвшилд

тулгуурласан шинэлэг шийдлээр үзүүлдэг нь Голомт банкны нэгэн давуу тал болж байна. Банкны хувьд хүчин чадал нөөц бололцоогоо ашиглан компанийн сайн засаглалтай, ил тод байдлаар улсын эдийн засагт чухал хувь нэмэр оруулж ажиллахыг эрмэлздэг. Голомт банк зах зээл дээрх хамгийн шилдэг туршлагыг нэвтрүүлсэн үлгэр жишээ банк болж, харилцагчдадаа болон салбартаа илүү ээлтэй эерэг нөлөөллийг авчрахыг эрэлхийлж байна.

- Олон улсын туршлагаас харахад банкууд ихэвчлэн төрөлжсөн үйл ажиллагаа явуулдаг. Голомт банкны хувьд аль чиглэлд түлхүү анхаарч байгаа вэ? Ер нь манай улсын банкуудын хөгжих чиглэл ямар байна вэ?

Банкны салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөлжилт нь ярилцвал зохих чухал сэдвүүдийн нэг. Монголын банкууд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэхэд харьцангуй бэлэн, өрсөлдөхүйц гэж би боддог. Гэхдээ асуудал нь зах зээлийн хэмжээ эсвэл банкнаас бусад санхүүгийн зах зээлийн хөгжил нь төдийлөн бэлэн болоогүй. Цаашлаад санхүүгийн секторын дэд бүтэц, түүний зохицуулалт, эрх зүйн орчин нь мөн хангалттай бэлэн биш байна. Банкууд шинэ бүтээгдэхүүн гаргахдаа бэлэн хэдий ч дээр дурдсан болон бусад зүйлийн нөлөөллөөр тэдгээрийн үр ашигтай байдал, өсөлт тодорхой бус байдаг нь хүндрэл болж байна.

- Төрөлжилтийг бий болгосноор банкуудын өрсөлдөөн нэмэгдэх боломжтой. Тэгвэл манай банкууд хэр төрөлжиж, цаашлаад өрсөлдөөнд хэр идэвхтэй байгаа гэж харж байгаа вэ?

Миний бодлоор энэ нь хоёр талтай зүйл. Банкууд идэвхтэй байхыг эрмэлзэж тэр нь идэвхтэй өрсөлдөөнийг зах зээлд бүрэлдүүлж, зогсолтгүйгээр шинэ бүтээгдэхүүн гаргах боломжуудыг эрэлхийлж байна. Гэхдээ нөгөө талаар хууль эрх зүйн орчин өрсөлдөөнд бэлэн байгаа эсэхээс үүдэн банкуудад болгоомжлох шаардлага тулгарч байна.

- Арилжааны банк сонгодог утгаараа Монголд хөгжих боломж хэр бүрдсэн гэж үзэж байна вэ? Та туршлага дээрээ үндэслэж бусад улстай харьцуулахад ямар дүр зураг гарч байна?

Банкууд эдийн засгийн уналт өсөлтийн мөчлөгт мэдрэг байсаар ирсэн ч Монголын банкны сектор сүүлийн жилүүдэд ДНБ-ий өсөлтийг давж өссөн. Өөрөөр хэлбэл, эдийн засаг хүндрэхэд банкуудын үйл ажиллагаа суларч, эдийн засаг сэргэхэд дагаж өсдөг гэсэн үг. Гэхдээ сүүлийн хугацаанд тохиосон эдийн засгийн хүндрэлүүдийн дараа банкууд эрсдэлийн тогтолцоогоо илүү сайжруулж, эрсдэлийн удирдлагын техникээ хөгжүүлж, хөгжих зөв чиглэл рүүгээ шат шатаар ахиж байна.

- Банкны хөгжилтэй холбогдуулаад олон улсын туршлагаас харахад олон нийтэд нээлттэй банк бий болоход санхүүгийн хүртээмж нэмэгддэг. Энэ туршлагыг Монголд нэвтрүүлэх нь цаг үеийн хувьд хэр тохиромжтой вэ?

Банкны нийгэмд үзүүлэх нөлөө чамгүй их. Банкны салбарын хувьд биржид бүртгэлтэй нээлттэй банкт байх нь нэг чухал зорилго бөгөөд банкиг биржид бүртгүүлж, олон нийтэд санал болгох нь хөгжлийн эерэг бөгөөд чухал шат юм. Энэ нь банкны ил тод, нээлттэй байдлыг ахиулж, улмаар итгэлцлийг нэмэгдүүлэх нөлөөтэй байдгаас гадна дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг ч татах боломжтой болдог.

- Төв банк 2020 оны Мөнгөний бодлогын үндсэн чиглэлдээ олон нийтэд нээлттэй банкт болох зорилтыг тавьсан байгаа. Үүн дээр банкууд хэрхэн бэлтгэж, ялангуяа Голомт банк хэрхэн оролцох төлөвтэй байна вэ?

Тийм ээ, Монголын банкууд цөөхөн хувьцаа эзэмшигчидтэй, хувьцааны төвлөрөл өндөртэй байдаг учраас хувьцаа эзэмшигчдийн бүтцийг төрөлжүүлж, илүү олон хувьцаа эзэмшигчидтэй болох нь эерэг зүйл. Голомт банкны хувьд ч үүнийг анхаарч, хувьцаа эзэмшигчдийн бүтцээ төрөлжүүлэхээр ажиллаж байна. Манай банк шинэ хувьцаа эзэмшигч, түнштэй болох тал дээр бүрэн нээлттэй байдаг. Ирээдүйд биржид бүртгүүлэх нь ирээдүйн эерэг зорилго байж болох юм.

- Хэр их хугацаа шаардлагатай вэ? Манай хөрөнгийн зах зээлийн хөгжлийн боломж, хөрс нь ямар байгаа вэ?

Монголын хөрөнгийн биржид томоохон банк

бүртгүүлэхэд хөрөнгийн зах зээлийн хөгжил чухал, гэхдээ Монголын хөрөнгийн зах зээл үүнийг гүйцэлдүүлж чадах эсэх нь өөрөө чухал асуулт юм. Зах зээл дээрх хөрөнгө оруулагчдын бааз суурь, нөгөө талаас томоохон банкны хувьцааг худалдан авч шингээх бололцоо хэр байна вэ гэдгийг анхаарах хэрэгтэй. Миний бодлоор Монголын хөрөнгө оруулагчдын бааз тэлж банкнаас бусад байгууллагын хөрөнгө оруулагчид хөгжиж байж томоохон банкны хувьцааг худалдан авах чадамжтай болно. Эсвэл банк дотоодын болон гадаадын хөрөнгийн биржүүд дээр давхар бүртгэл хийж болно. Тухайлбал Хонгконг, Монгол хоёр улсын биржид давхар бүртгэл хийх боломжтой. Олон улсын биржийн стандартыг дагах, ил тод байх зэрэг нь сорилт болох ч энэ нь харьцангуй эерэг юм. Гэхдээ одоогийн нөхцөл байдалд биржид бүртгүүлэх явц нь ихээхэн цаг хугацаа орох ажил, Голомт банкны хувьд ч мөн адил. Харин үүнд бэлтгэл болгож банкууд үүнээс наана боломжийг ашиглаж, шинэ сайн хувьцаа эзэмшигчтэй болж төрөлжилтийг нэмэгдүүлж, засаглалыг сайжруулж болно.

- Бидний яривал зохих өөр нэг асуудал бол харилцагчдын эрх ашиг. Харилцагчдын эрх ашгийг хамгаалахад банкны найдвартай, тогтвортой үйл ажиллагаа чухал байдаг. ХБНГУ-ыг жишээ татахад харилцагчийн эрх ашгийг хамгаалахын тулд харилцагчид зөвлөх үйлчилгээг хөгжүүлсэн байна. Танай банкны хувьд үүн дээр хэрхэн анхаарч ажиллаж байгаа вэ?

Юун түрүүнд банк нь шинэ технологи, процедур нэвтрүүлэх зэргээр үйл ажиллагаагаа илүү үр бүтээмжтэй байлгахад анхаарч, зардлаа бууруулах замаар хямд бөгөөд тохиромжтой үнийг харилцагчдадаа санал болгох нь зүйтэй. Хоёрдугаарт, банк бүтээгдэхүүнээ танилцуулахад анхаарч, харилцагчийг санхүүгийн зөв шийдвэр гаргахад туслах, үүний тулд вебсайт эсвэл салбарын ажилтнаараа дамжуулан энгийн үг, хэллэгтэйгээр, ойлгомжтой байдлаар харилцагчид мэдээлэл өгөх хэрэгтэй. Харилцагч бүтээгдэхүүний давуу тал, эрсдэлийг ойлгосноор зөв шийдвэр гаргах бөгөөд ингэснээр харилцагчийг хамгаалах маш чухал алхам болох юм. Бүтээгдэхүүнийг танилцуулахаас гадна банкир өөрөө зогсолтгүйгээр суралцсанаар харилцагчийн цаг үеийн асуудалд хариулахад

бэлэн байхад тусалж, хэрэгцээг хангах замаар тогтвортой өсөлтийг нөхцөлдүүлж чадна. Банкны уламжлалт боловсролоос гадна, жишээлбэл тогтвортой хөгжлийг бий болгохыг зорьж байгаагийн хувьд банкны ажилтан хүлэмжийн хий ямар нөлөө үзүүлдэг тухай, үүнийг хэрхэн бууруулах боломжтой, ингэснээрээ санхүүжилтийн тал дээр ямар давуу тал бий болох боломжтой талаар ч мэдээлэл өгч чаддаг байх хэрэгтэй. Тиймээс банкны ажилтан хүн харилцагчдаа тухайн нөхцөл байдалд тохирсон зөв, сайн мэдээлэл өгөхийн тулд илүү ихийг судалж мэдэх шаардлагатай юм.

- Харилцагчийн эрх ашгаас гадна нөгөө талд нь банкны эрх ашиг ч мөн байгаа. Монголд ирээд ажиллахад манай банкны эрх зүйн орчин, банк тогтвортой ажиллахад дэмжлэг болох хамгаалалтын механизм хэр оновчтой байна вэ?

Миний туршлагаас үзэхэд, хөгжиж байгаа улсуудтай харьцуулахад Монголын банкны эрх зүйн орчин сайн. Гэхдээ хууль журмын хэрэгжилт дээр анхаарч, сайжруулах зүйл байгаа гэж хэлнэ. Мөн зарим суурь дэд бүтцийн асуудал, тухайлбал зээлийн мэдээллийн алба зэрэг дэд бүтэц тал дээр илүү үр бүтээмжтэй болгох шаардлагатай зүйлс байна. Хэдийгээр хөдлөх хөрөнгийн барьцаа хөрөнгийн эрх зүйн орчин сайжирч байгаа ч бүрэн дүүрэн хэрэгжээгүй байна. Банк санхүүгийн салбарын дэд бүтцүүдийг сайжруулснаар бүх банканд үр өгөөжтэй байх учраас банкууд Төв банктэйгаа хамтран ажиллах хэрэгтэй. Ингэснээр салбарын хэмжээнд үргүй зардлыг багасгаж, банкны үйлчилгээг илүү үр ашигтай болгох давуу талтай юм.

- Дараагийн асуултаа цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулж асуухыг хүсч байна. Бид онцгой нөхцөл байдалд байна шүү дээ. Тэгэхээр ийм үед банк харилцагчдадаа хандсан ямар арга хэмжээ авч ажилладаг вэ? Тухайлбал, Япон улс байгалийн гамшигт илүүтэй өртөж байсны хувьд?

Хямралын удирдлага буюу зарим хүний сүүлийн үед ярьж буй "Хар хун" нь хэзээ ч төсөөлөх аргагүй нөхцөл байдлыг таамаглаж төлөвлөдгөөрөө чухал. Жишээлбэл, намайг Токио Мицубиши банканд ажиллаж байх үед Кобэд газар хөдөлж, төсөөлшгүй гамшиг



болж, үнэхээр онцгой нөхцөл байдал үүссэн. Бид 24/7 хуваариар ажиллаж, төслийн баг маань дайны цагийн зөвлөмжийг мөрдлөг болгож, харилцаа холбооны шугамыг ашиглан харилцаж, мэдээлэл солилцдог байсан. Дараа нь ч энэ туршлага маш их хэрэг болсон. Японы банкууд өдгөө гамшиг, онцгой нөхцөлд харьцангуй бэлэн байдалтай ажиллаж, гарын авлага ашиглаж, заримдаа бодит дадлагуудыг хийх зэргээр бэлтгэл ажлыг сайн хангадаг. Энэ нь гамшиг тохиохоос өмнө нэг их анхаарахаар зүйл биш мэт санагдаж болох ч илүү сайн бэлтгэлтэй байна гэдэг нь бүх зүйлийг тайван замаар хийхэд ихээхэн түлхэц болдог. Коронавирусын нөхцөл байдлын талаар ярихад, урт хугацаанд үргэлжилснээр эдийн засагт сөргөөр нөлөөлөх вий гэдэг нь санаа зовоосон асуудал болж байна. Вирусын улмаас эрсдэлтэй нөхцөл байдал үүслээ гэхэд бид харилцагчдадаа ямар дэмжлэгийг өгч чадах вэ? гэдэг чухал. Би үүнийг хараахан “форс мажор” гэж хэлэхгүй. Арилжааны гэрээнд заасан нөхцөл хангагдаж байх ёстой гэсэн үг. Гэхдээ туйлын хүнд нөхцөл байдал бий болсон үед Засгийн газраас арга хэмжээ авахыг хичээж, банкуудын хувьд тогтоосон хүү нөхцөлийнхөө хүрээнд хүндрэлтэй байдалд дэмжлэг үзүүлж, боломжийнхоо хэрээр чадах зүйлсээ хийх болов уу.

- Энэ үед бизнес эрхлэгчид зээлийн хүүг бууруулах талаар саналаа хэлж байгаа. Голомт банкны зүгээс нөхцөл байдлыг хэрхэн харж байна вэ?

Банкны бүтээгдэхүүний үнэ гэдэгт зээлийн хүү болон хадгаламжийн хүүг авч үздэг. Бүтээгдэхүүний үнэ нь зах зээлийн суурь зарчмыг дагах ёстой. Хэрэв үүнийг зөрчвөл банкны салбар тогтвортой байж чадахгүй. Хэрэв хүүг зохиомлоор тогтооно гэвэл дээр хэлсэнчлэн банк үр ашигтай байдлаа хангаж, ашигт ажиллагаагаа хадгалах хэрэгтэй болно. Зохиомлоор биш, суурь бизнесийн үйл ажиллагаагаа сайжруулж, үр ашгаа дээшлүүлэх замаар цэвэр хүүгийн ахиуц багассан ч тодорхой хэмжээний ашигтай ажиллах хэрэгтэй. Бид бусад банктай тогтвортой өрсөлдөөнөө хадгалахын тулд тохиромжтой үнийг санал болгодог. Харилцагчид ч энэ талаар ойлголттой байдаг гэж бодож байна. Өрсөлдөөний механизм ажиллаж байна. Эдийн засгийн суурь, үр ашигт байдал, эрх зүйн орчны нөлөө, чанаргүй зээлийг төлүүлэх гэх мэт бүх зүйлсийн нөлөө банкны зардлыг нэмэгдүүлж, хүүг тогтоож өгдөг. Зөвхөн нэг банкны биш, системийн үр ашигт байдал чухал бөгөөд энэ нь эргээд санхүүгийн зардлуудыг бууруулж, эцэстээ зээлийн хүүг бууруулахад дэмжлэг болно. Ийм зарчмаар ажиллахад тогтвортой өсөлт бий болох юм.

- Коронавирусын эрсдэлийн энэ үед танайх ямар арга хэмжээ авч байна вэ?

Би банкныхаа ажилтнуудаас харилцагчидтай байнгын харилцаатай ажиллахыг хүсдэг. Харилцагчид хүндрэлтэй тулгарч байна уу, бид тэдэнд дэмжлэг үзүүлэхийн тулд хэрхэх

гэх мэт асуудлуудыг тавьж байна. Энэ бол банкны чадавх болон профессионализмыг шалгах цаг. Би ажилтнуудаа бусдаас нэг алхам түрүүлж харах, дараа нь юу болохыг таамаглаж байхыг хүсдэг. Нөхцөл байдал үргэлжилбэл юу болохыг тооцоолж, аль секторын харилцагчид илүү хохирох, бид хамтаараа юу хийж чадах вэ гэсэн асуултад хариулах хэрэгтэй. Манай Зээлийн газрынхан стресс анализ хийж, ямар төрлийн нөлөө бий болох, хэр их харилцагчид үүнд өртөх, мөнгөн урсгалын дүн хүртэл яаж өөрчлөгдөх үү гэх зэргийг тодорхойлох заавар өгч, ажиллаж байна.

Коронавирусын нөхцөл байдал үргэлжилбэл үр нөлөө нь томоохон байж болзошгүй байна. Тиймээс харилцагчидтайгаа байнгын харилцаатай байх нь маш чухал.

- Бидний ярилцлага эхэлсэн цагаасаа банкны салбарт төвлөрлөө. Харин үлдсэн цөөн хоромд таны тус салбарт ажилласан туршлагаас сонирхох хүсэлтэй байна?

Миний хувьд Япон Улсын банкны салбарт багагүй хугацаанд ажилласан. Японы эрх зүйн орчин нилээд хөгжсөн. Гэсэн хэдий ч асуудал байсаар л байна. Японд эдийн засаг, санхүүгийн маш том хямрал 1998-1999 онд тохиож, тухайн үед банкуудын зээл асуудалд орж хүндэрч байсан юм. Гэхдээ сорилтуудыг даван туулсаар хөгжсөн улс орнуудын банкны салбартай зэрэгцэж, улам бүр чадавхжсан. Эндээс дүгнэхэд мэдээж хөгжиж байгаа орнуудын хувьд тухайлбал, Монголын банкны салбарыг хөгжсөн орнуудтай харьцуулахад сул. Банкуудын санхүү, хөрөнгийн бүтэц нь хөгжилтэй орнуудынхтай харьцуулахад тийм ч хүчтэй биш учраас банкууд санхүүгийн чадавхиа сайжруулах нь зүйтэй. Мөн засаглалын бүтцээ сайжруулах орон зай бидэнд бий. СТОУС зэрэг Олон улсын стандартыг мөрдлөг болгох хэрэгтэй гэж үздэг. Туршлагынхаа тухай ярихад, би карьераа анх Токиогийн банкнаас эхэлсэн. Тус банк удаа дараагийн бүтцийн өөрчлөлт, нэгдлийн дараа одоо бол MUFJ нэртэй болсон л доо. Би 28 жил ажилласны эцэст 2009 онд Монголд ирж ажилласан. Тухайн үед Хаан банканд ахлах зөвлөхөөр ажиллаж, дараа нь гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч, гүйцэтгэх захирлаар 5 жил ажилласан. Түүний дараахан надад Камбожид шинээр үүсгэн байгуулагдсан банканд ажиллах боломж бүрдсэн. Тэнд би 2 жилийн турш шинэхэн банкны бүтэц, үйл

ажиллагааг нь тогтворжуулахад анхаарч ажиллахад Хаан банкнаас хуримтлуулсан туршлага багагүй хэрэг болж байсан нь тод санагдаж байна. Улмаар би Монгол Улсад эргэн ирж, одоо Голомт банкны удирдлагаар ажиллаж байна. Би Монголд эргэж ирэхдээ их баяртай байсан. Намайг эргэж ирэхэд Голомт болон Хаан банкны найзууд маань бүгд сайхан угтаж авсан. Намайг ийнхүү таатай угтаж авсанд би маш их талархсанаа энэ дашрамд уламжлахыг хүсч байна.

- Та манай банкны салбарт ямар туршлагыг нэвтрүүлэхийг хүсч байна вэ?

Миний бодлоор банкны бизнес бол ихээхэн бодитой, рациональ юм. Эрх зүйн орчин зохистой байж, тэр нь мөрдөгдөж, банкууд үргэлж рациональ шийдвэр гаргах хэрэгтэй. Банк ямар нэг улс төрийн болон бусад нөлөөлөлд автахгүй байх ёстой. Банкны үйлчилгээний нийгэмд үзүүлэх нөлөө нь маш том. Тиймээс бид илүү нээлттэй байж, ул суурьтай шийдвэр гаргаж байж тогтвортой байж чадна.

Хөгжсөн орнуудын хувьд банкууд нь ч, харилцагчид нь ч, аль аль нь хамгийн зөв алхам юу вэ, ямар шийдвэр, туршлага нь үр дүнтэй вэ гэдгийг мэддэг. Энэ бол миний бодлоор нэгдсэн дүгнэлт болов уу. Монголын хувьд хүний нөөцийн хувьд ихээхэн бололцоотой. Би сүүлийн үед боловсорч, хөгжсөн мэргэжилтнүүдийг улам олон болж байгааг харж байна. Нөгөөтэйгүүр, банкны салбарын өдөр тутмын харилцаа сайжирч, мэдээллийг харилцагчид тухай бүр өгч байна. Энэ нь илүү бодитой, рациональ шийдвэр гаргахад хүргэж, харилцагчид болон банкуудын үр ашигтай байдлыг нэмэгдүүлж байна.

Ярилцсанд баярлалаа.

ИРГЭДИЙН ХАДГАЛАМЖИД МЭДЭЭЛЛИЙН ТЭГШ БУС БАЙДАЛ НӨЛӨӨЛӨХ НЬ

Монголбанкны ХШГ-ын ахлах хянан шалгагч Өлзийдэлэгийн Тайван

ОРШИЛ

Аливаа зах зээл дээр бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад өрсөлдөөн зайлшгүй чухал байдаг. Банкны зах зээл дээр хэрэглэгчдэд найдвартай үйлчилгээг хүргэх, тэр дундаа хадгаламжийн зах зээлийн үр ашиг, үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд өрсөлдөөний орчныг бий болгох хэрэгцээ шаардлага чухал байдаг. Тиймээс банкны төлбөрийн чадвар, өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт өндөр, чанартай санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээтэй, найдвартай үйл ажиллагаатай банкуудыг зах зээлд гарч ирэх, улмаар энэхүү зах зээлд үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлэх нь банк санхүүгийн зах зээлийн тогтвортой байдалд чухал хэрэгтэй юм. Хадгаламжийн зах зээл дээр цөөн тооны том банкуудын ноёрхол нь жижиг банкуудын санхүү, төлбөрийн чадварын мэдээлэл тэгш бус байгаатай холбоотой. Мэдээллийн тэгш бус байдал нь зарим хариуцлагатай, найдвартай банкуудыг зах зээлээс гарах нөхцлийг бүрдүүлдэг. Иймд хариуцлагатай банкиг зах зээлд үйл ажиллагаа явуулах боломжийг бүрдүүлэхийн тулд мэдээллийг нь харилцагчид, хадгаламж эзэмшигчдэд хүргэх шаардлагыг зохицуулагч байгууллагын зүгээс тавих нь зайлшгүй чухал юм.

Монгол Улсын хадгаламжийн зах зээлийн нөхцөл байдал

Иргэдийн хадгаламжийн зах зээлд хадгаламжийн бодит хүү 1994 оноос эхэлж эерэг болж, хадгаламжийн хэмжээ нэмэгдэж ирсэн.




График. Иргэдийн хадгаламжийн динамик (их наяд төгрөгөөр)

Эх сурвалж: Монголбанк, 2019. <http://www.mongolbank.mn/> (2019/11/10).



Хадгаламжийн бодит хүү эерэг болсон нь Төв банкнаас явуулж байсан бодлогын үр дүн юм. Иргэдийн хадгаламжийн хэмжээ 1993 оноос хойш ерөнхий дүнгээрээ нэмэгдсэн ба 2019 оны 3 дугаар улирлын байдлаар өсөлттэй гарчээ. Гэхдээ хадгаламжийн зах зээлийн үр ашиг өндөр байж чадаагүй байна. Үүнийг дараах хэд хэдэн зүйлтэй холбоотойгоор тайлбарлаж болно.

Нэгдүгээрт, зах зээлийн цар хүрээг нэмэгдүүлэх боломжийн ашиглалт бага байна. Мөн сүүлийн үед нийт хадгаламжийн өсөлтийн ихэнхи хувийг гадаадын валютын хадгаламжийн өсөлт хангажээ. Тухайлбал, 2019 оны 3 дугаар улиралд хадгаламжийн хэмжээ өмнөх улирлынхаас 1.4 хувиар нэмэгдсэнийг гадаад валютын хадгаламж 5.4 хувиар нэмэгдсэнээр тайлбарлаж байна. Өөрөөр хэлбэл, эдийн засагт долларжилт өндөр байгаа нь иргэдийн төгрөгийн хадгаламжийн хэмжээг өсгөхөд саад болж байна.

Хоёрдугаарт, хадгаламжийн зах зээлийн дийлэнх хувийг эзэлдэг банкуудын татан төвлөрүүлсэн хөрөнгийн 42.8 орчим хувь нь иргэдийн хадгаламж байхад, бусад банкуудын хувьд 26 орчим хувь байна.

Эндээс дүгнэхэд, хадгаламж эзэмшигчид өөрсдийн хадгаламжийг эрсдэлгүй байхад голлон анхаарч байна.

Гуравдугаарт, хадгаламжийн зах зээлд төвлөрөл өндөр байна. 2019 оны 3 дугаар улирлын байдлаар хадгаламжийн зах зээлд дийлэнх хувийг эзэлдэг 5 банкны нийт хадгаламжийн үлдэгдэлд эзэлж байгаа хувь 93.6 байгаа бол бусад 8 банкных 6.4 хувь байна.

Дөрөвдүгээрт, хүмүүсийн бодит орлого бага байгаа нь хадгаламжийн хэмжээ өндөр байж чадахгүй байгаагийн суурь шалтгаан юм. Статистикийн төв газрын мэдээг үзэхэд өрхийн зарлагын бүтцэд эзлэх хадгаламжийн хэмжээ маш бага буюу 2018 оны эцсээр 4.5 орчим хувьтай байна.

ХАДГАЛАМЖИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ ТЭГШ БУС МЭДЭЭЛЛИЙН НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭ

Зах зээлд чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэгчид нь худалдан авагчдад тэр бүр өртөөд байдаггүй. Хадгаламжийн зах зээл дээрх тэгш бус мэдээллийн нөлөөллийг авч үзэхийн тулд банк болон хадгаламж

эзэмшигчийн хооронд хийгдэх гэрээний хүрээнд банкны талаарх мэдээллийн өрөөсгөл байдал гэдэгт юуг ойлгож болох талаар үзье. Ямар ч банкны татан буугдах магадлал нь тэдгээрийн үйлчлүүлэгчдэд мэдэгдэх боломжгүй байдаг. Банк иргэд, байгууллагаас татсан хадгаламжид хүү төлөх ба хадгаламж эзэмшигчийн эрсдэлийн шагнал нь (Энэ нь эрсдэлгүй хөрөнгө оруулалтаас авах хүү болон тухайн банкны хадгаламжийн хүүгийн хоорондын зөрүү) хангалттай өндөр гэж үзсэн тохиолдолд л банктай хадгаламжийн гэрээг хийнэ. Хэрэв банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлийн талаарх мэдээлэл нь "тэгш" буюу өөрөөр хэлбэл, үнэн зөв байх үед татан буугдах магадлал нь өндөр байх тусам харилцагчдыг татахын тулд банк өндөр хүү тогтоох хэрэгтэй болно. Мэдээллийн тэгш бус буюу өрөөсгөл байдал гэдэг нь харилцагч аль ч банкны татан буугдах магадлалыг тодорхойлж чадахгүй байх нөхцөл байдлыг хэлнэ. Энэ тохиолдолд, хадгаламж эзэмшигч банкуудын төлбөрийн чадварын эрсдэлийг хооронд нь харьцуулахад хүндрэлтэй байдаг.

Харилцагчийн хувьд санамсаргүй сонгож авсан банкны татан буугдаж магадгүй гэсэн хүлээлт нь зах зээл дээр илүү тогтвортой үйл ажиллагаа явуулж буй банкныхаас өндөр байдаг. Хадгаламж эзэмшигчидтэй гэрээ хийхийн тулд банкууд тэр дундаа үйл ажиллагаа нь тогтворжсон байгаа банкууд нь банкны татан буугдаж магадгүй байх гэсэн хүлээлттэй зохицуулж, өндөр хүүг тогтооно. Харин төлбөрийн чадвар өндөр, өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт өндөр, татан буугдах эрсдэл багатай банкуудын хувьд тэр хүү нь хэтэрхий өндөр байх юм. Энэ тохиолдолд татан буугдах магадлал нь илүү бага банкууд хадгаламж эзэмшигчидтэй гэрээ хийхээс татгалзах нөхцөл байдалд хүрнэ. Зах зээл дээр төлбөрийн чадваргүй болох эрсдэл өндөртэй банкууд үлдэнэ. Энэ нь хадгаламж эзэмшигчдийг урвуу сонголт (adverse selection) хийх байдалд хүргэнэ гэсэн үг. Энэ хирээр томоохон банкуудын зах зээл дээрх ноёрхол нэмэгдэнэ.

Хоёр шатлалтай банкны систем үүсгэн

байгуулагдсаны дараах үе болон 1990-ээд оны сүүлээс 2006 он хүртэл иргэдийн хадгаламжийн зах зээлд банкуудаас гадна хадгаламж, зээлийн хоршоод зэрэг бусад банкны бус санхүүгийн байгууллагууд үйл ажиллагаа явуулж байсан. Эдгээр нь банкуудын хадгаламж эзэмшигчдийн үйл хөдлөлд нэлээд хэмжээгээр нөлөөлсөн байдаг. Шинэ гарч ирж байгаа банкууд төрийн өмчийн болон түүний суурин дээр байгуулагдсан банкуудтай харьцуулахад нөхцөл байдлын хувьд хүндрэл, бэрхшээл туулж үйл ажиллагаа явуулж эхэлсэн байдаг. Иймээс үйл ажиллагаа нь тогтвортой, төлбөрийн чадвар сайтай, өөрийн хөрөнгийн хүрэлцээ өндөр байгаа банкуудын хувьд өөрсдийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг (өөрөөр хэлбэл, санхүүгийн бодит байдлынхаа талаар) хадгаламж эзэмшигчдэд хүргэх шаардлагатай байдаг. Харьцангуй жижиг, үйл ажиллагаа нь хадгаламжийн зах зээлд бага хувь эзэлж байгаа банкуудын хувьд хадгаламж эзэмшигчдэд чиглэсэн зах зээлийн эерэг дохиоллыг бий болгоно гэдэг нь хүнд зорилт байдаг. Учир нь хадгаламжийн зах зээлд дийлэнх хувийг эзэлдэг, үйл ажиллагаа нь тогтвортой явагдаж байгаа том банкуудтай харьцуулахад тэдгээр банкууд "тогтвортой" гэж болох нэр хүнд харьцангуй бага юм. Иймд нэр хүнд олж авах зардал (шууд болон шууд бус) нь тэдний хувьд өндөр байдаг.

Манайд 1996-1997 онуудад Төв Ази, Ард, Даатгал банкууд, 2008 онд Анод банк, 2009 онд Зоос банк, 2013 онд Хадгаламж банк, 2019 оны 4 дүгээр сард Капитал банкиг татан буулгахад банкны системд итгэх хадгаламж эзэмшигчдийн итгэл маш их суларсан. Банкуудад итгэх итгэл суларсан нь харилцагчдын хувьд рациональ бус хүлээлтийг бий болгож, харилцагчдын зүгээс жижиг банкуудад хандах хандлагыг зөв тодорхойлоход сөргөөр нөлөөлж байна. Хүмүүс жижиг банкуудад мөнгөө хадгалуулах нь бага байгаа нь зарим төлбөрийн чадвар сайтай жижиг банкуудын хувьд үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд саад болж байгаа юм. Тэдгээрийн хувьд зах зээл дээр үйл ажиллагаагаа явуулж буй томоохон банкуудтай харьцуулахад нэр хүндийн зардал

маш өндөр байдаг гэсэн үг. Ер нь банкуудын үйл ажиллагааг татан буулгахад зах зээл дээр сөрөг дохиолол бий болж, бусад жижиг банкуудын үйл ажиллагаанд муугаар нөлөөлдөг. Үүнээс болж шинэ, төлбөрийн чадвар сайтай банкуудад нэр хүндийн (зар сурталчилгааны болон бусад) зардал

өндөрсөж, ашигийг бууруулж, тэдгээрийн үйл ажиллагаанд бэрхшээл учруулдаг байна. Энэ нь банкны зах зээл дээр хэрэглэгчдийн хувьд урвуу сонголт үйлчлэх нөхцөлийг бий болгох, цаашилбал, банк санхүүгийн системийн тогтворгүй байдалд хүргэдэг.

ДҮГНЭЛТ

Хадгаламжийн зах зээл дээр дараах хоёр үндсэн бэрхшээл тулгарч байна гэж үзэж болно. Үүнд:

Харилцагчдад банкуудын санхүүгийн бодит байдлын талаарх мэдээлэл дутагдаж байна.

Хадгаламж эзэмшигчдийн ихэнх нь тэр мэдээллийг ижил хэмжээнд судлан тайлбарлаж чадахгүй байна.

Мэдээллийн тэгш бус байдал нь зах зээл дээр төлбөрийн чадвар сайтай банкуудын үйл ажиллагаанд саад болдог бөгөөд хадгаламжийн зах зээл дээр цөөн тооны том банкуудын ноёрхол нь жижиг банкуудын санхүү, төлбөрийн чадварын мэдээлэл тэгш бус байгаатай холбоотой юм. Мэдээллийн тэгш бус байдал нь зарим хариуцлагатай, найдвартай банкуудыг зах зээлээс гарах

нөхцлийг бүрдүүлдэг байна. Олон улсын туршлагаас үзэхэд тэгш бус мэдээллийн нөлөөллийг бууруулахын тулд хадгаламж татан төвлөрүүлдэг байгууллагууд буюу банкуудыг бүгдийг нь болон зарим хэсгийг төр өөрийн мэдэлд авах замаар хадгаламж эзэмшигчдэд баталгааг хангах тохиолдол байдаг. Санхүүгийн зах зээл өндөр хөгжсөн улсуудад банкуудыг заавал даатгадаг системийг бүрдүүлсэн байдаг. Тэр дундаас олон улсын үнэлгээний байгууллагуудаас тогтоодог үнэлгээг хадгаламжийн даатгалын тогтолцоотой хослуулан нэвтрүүлэх хувилбарыг хэрэгжүүлэх нь илүү оновчтой юм.

ТЭТГЭВРИЙН ТОГТОЛЦОО ОЛОН УЛСАД

Өндөр насны тэтгэвэр бол ахмадуудын амьжиргааны гол эх үүсвэр. Тухайн улс орны хөгжлөөс хамааран тэтгэврийн орлогын өрхийн хэрэглээний зардалд эзлэх хувийн жин өөр өөр байдаг. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас гаргасан судалгаанаас үзэхэд хөгжингүй орнуудад өндөр. Хөгжиж буй, буурай хөгжилтэй орнуудад бага байна гэжээ. Тухайлбал, Люксембург, Франц, Австри зэрэг орны иргэдийн хувьд өрхийн хэрэглээний 20-30 хувийг тэтгэврийн орлогоороо санхүүжүүлэх боломжтой бол манай улсад 9%, Мексик, Исланд, Чили зэрэг оронд 2-3% байдаг байна. Эндээс үзэхэд нийгмийн даатгалын тогтолцоо сайн хөгжсөн орнуудын тэтгэврийн хэмжээ өндөр тул зээл авах шаардлага бага, зайлшгүй тохиолдолд хуримтлалаасаа урьдчилж авах боломжтой байдаг. Харин нийгмийн даатгалын тогтолцоо хөгжиж байгаа, бага орлоготой улсуудын хувьд тэтгэврийн хэмжээ амьжиргааны зардалд хүрэлцдэггүй тул зээлийн шаардлага өндөр байдаг байна.

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

Дэлхийн улс орнууд нийгмийн даатгалыг хэрэгжүүлэхдээ хуваарилалтын болон хуримтлалын гэсэн үндсэн хоёр хэлбэрийн тогтолцоог ашигладаг байна. Тэтгэврийн зээл нь тухайн улсын нийгмийн даатгалын тогтолцооноос хамаараад ялгаатай байдаг бөгөөд хуримтлалын тогтолцоотой улсуудын хувьд зээл авах шаардлага бага, гардаг зээл авах тохиолдолд хуримтлалын дансаа барьцаалах боломжтой байдаг. Харин хуваарилалтын тогтолцоотой улсын хувьд зээл нь илүү арилжааны шинжтэй, банк санхүүгийн байгууллагаар дамждаг байна. Монгол Улс нь хуваарилалтын буюу нэрийн дансны тогтолцоотой орон юм.

ХУРИМТЛАЛЫН ТОГТОЛЦОО

Энэхүү тогтолцоо нь даатгуулагчийн төлсөн

шимтгэл нэрийн дансанд хуримтлагдах бөгөөд захиран зарцуулах эрх нь тэтгэвэрт гарсны дараа бүрэн нээгддэг байна. Өөрөөр хэлбэл, хуримтлуулсан хөрөнгөө олон жил хувааж авах эсвэл нэг дор бүгдийг авах эсэх нь тухайн даатгуулагчийн эрхийн асуудал юм. Дэлхийн ихэнх хөгжингүй оронд тус тогтолцоог ашиглан тэтгэврийн даатгалыг хэрэгжүүлдэг бөгөөд зөвхөн ажил олгогч эсвэл ажилтан, ажил олгогч хамтран шимтгэл төлж, тэтгэврийн санг бүрдүүлдэг байна. Мөн хуримтлагдсан шимтгэлээр хөрөнгө оруулалт хийж ирээдүйд авах тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх боломжтой байна. Тус тогтолцоог ашиглах нь тэтгэврийн насны иргэн нийт хуримтлуулсан шимтгэлийнхээ тодорхой хэсгийг урьдчилан авах боломжийг олгодог. Тухайлбал, АНУ-д тэтгэврийн насны иргэд өөрийн нэрийн данснаас тэтгэврээ 100% урьдчилан авах боломжтой бөгөөд 25 хүртэлх хувьд татваргүй, үлдсэн 75%-д орлогын албан татвар ноогдуулдаг байна. Иймээс өндөр настнууд тэтгэврийнхээ тодорхой хувийг урьдчилж авах, үлдсэн хэсгийг сар бүр ижил дүнгээр авах зэрэг хувилбаруудаас сонголтоо хийдэг. Мөн тэтгэврийн орлого болон үл хөдлөх хөрөнгөө барьцаалж зээл авах боломжтойгоос гадна амьжиргааны доод түвшний орлоготой өндөр настнууд хөнгөлөлттэй зээл авдаг байна.

Тэтгэврийн хөнгөлөлттэй зээл олгох туршлага Австрали улсын хувьд АНУ-тай адил хуримтлалын тогтолцоог ашигладаг бөгөөд өндөр настнуудад зориулсан тэтгэврийн зээлийн схемтэй байна. Зээл хүсэгч нь өөрийн эзэмшлийн үл хөдлөх хөрөнгийг барьцаалснаар зээл авах эрхтэй болох юм. Зээлийн дээд хэмжээ нь нийт хуримтлагдсан шимтгэлийг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх бөгөөд барьцаа хөрөнгө, нас, тэтгэврийн хэмжээ зэргээс хамаарч ялгаатай тогтоогдоно. Тус зээлийн эргэн төлөлтийн хуваарийг зээлдэгчийг дарамтанд оруулахгүй байх

үүднээс 14 хоног бүр үндсэн төлөлт тэнцүү байхаар зохиодог бөгөөд заавал хуваарийн дагуу төлөх албагүй байна. Мөн жилийн 5.25%-ийн нийлмэл хүүг зөвхөн зээлийн төлөөгүй үлдэгдэлд бодох бөгөөд тухайн сард ногдох үндсэн төлөлтөд хүү бодохгүй байна. Мөн АНУ, Өмнөд Африк, Мексик, Сингапур зэрэг хуримтлалын тогтолцоотой орнуудад хүмүүс тэтгэврийн сан болон ажил олгогчтойгоо тохиролцсоны үндсэн дээр өөрийн хуримтлагдсан шимтгэлийг барьцаалан тэтгэвэрт гарахаас өмнө үл хөдлөх хөрөнгийн зээл авах боломжтой байна. Энэ нь тухайн хүний амьдрах орчны таатай байдлыг нэмэгдүүлэх зорилготой. Зарим орнуудад ийм төрлийн зээлийн дуусах хугацааг тэтгэвэрт гарах насаар тогтоодог бол зарим нь 30 хүртэл жилээр олгодог байна.

ХУВААРИЛАЛТЫН ТОГТОЛЦОО

Энэ нь орлогоороо зардлаа нөхдөг буюу өнөөдөр хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийн шимтгэлээр ахмад настны тэтгэврийн эх үүсвэрийг бүрдүүлдэг байна. Иргэд цалингийн тодорхой хувийг даатгалын системд төлөх бөгөөд тухайн хүний ажилласан жил, цалингийн түвшин, төлсөн шимтгэл зэргээс хамаарч тэтгэврийн хэмжээ тогтоогддог байна. Өндөр настнуудад хуримтлагдсан шимтгэл байхгүй тул тэтгэврээ урьдчилан авах боломжгүй юм. Тус тогтолцоог Монгол, Итали, Польш, Киргиз, Латви, Швед зэрэг оронд ашиглаж байгаа бөгөөд тухайн улсын эдийн засгийн чадамжаас хамаарч тэтгэврийн орлогоор амьжиргааны зардлаа санхүүжүүлэх боломж нь ялгаатай байна.

Дэлхийн ихэнх орнууд дээрх хоёр тогтолцоог хамтад нь хэрэгжүүлдэг байна. Засгийн газраас ихэвчлэн төрийн албан хаагч, тэр дундаа цэрэг армийн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хуваарилалтын тогтолцоог санал болгодог. Ингэхдээ тухайн албан хаагчийн тэтгэврийн хэмжээг Засгийн газраас тогтоож, хуримтлалын тогтолцоотой адил хэмжээний хөнгөлөлттэй зээл, тусламжийг үзүүлдэг.

ТЭТГЭВРИЙН ЗЭЭЛИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ БУСАД ОРОНД

Зарим судлаачдын хийсэн судалгааны үр дүнгээс харахад Америк, Европ, Азийн нэлээд хэдэн орны өндөр насны тэтгэвэр авагчдад хэрхэн зээл олгодог асуудлыг судалж үзэхэд өндөр насны улсаас олгодог суурь тэтгэврийг барьцаалан зээл олгохыг зохицуулсан “Тэтгэврийн зээлийн тухай” хуультай улс орон байхгүй ажээ.

Харин өндөр насны тэтгэвэрт гарсан хүмүүст банк ба бусад санхүүгийн байгууллагаас олгох зээлийн харилцаа нь банкны зээлийн талаарх эрх зүйн хэм хэмжээг зохицуулдаг гол эрх зүйн актууд, тухайн банкны зээлийн журмаар зохицуулагддаг байна.

Энэтхэг, Австрали зэрэг оронд өндөр насны тэтгэвэр авагчдад зайлшгүй шаардлагатай эмчилгээний төлбөр, гэр бүлийн хэрэгцээнд зориулан тодорхой хугацаагаар, тодорхой хэмжээний зээлийг хүүгүй олгодог ба Австралид Засгийн газраас нь тэтгэврийн насны зээл хүссэн иргэдэд зориулан дээрх хүүгүй зээлийг олгодог “Засгийн газрын тэтгэвэр авагчдад зориулсан дэмжлэг” нэртэй хөтөлбөрийг хэрэгжүүлдэг юм байна.

Их Британид 2002 онд Улсын тэтгэврийн кредитийн тухай хууль /State Pension Credit Act 2002/ батлан улсын нэмэлт тэтгэврийг амьжиргааны түвшнээс доогуур орлоготой, 65-аас дээш насны өндөр настнуудад улсын тэтгэвэр дээр нь нэмэлт тэтгэлэг байдлаар олгодог байна.



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК



ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРАЛ

2020

Зорилго:

Эдийн засаг, статистик болон санхүүгийн чиглэлээр судалгаа шинжилгээ хийдэг судлаач, эрдэмтэд болон оюутнуудын судалгааг дэмжих, бүтээлийг нь нийтэд түгээн дэлгэрүүлэх, бодлого боловсруулахад оролцох оролцоог нь нэмэгдүүлэхэд оршино.

ОЮУТАН

- ① Өргөмжлөл, 1 000 000₮
- ② Өргөмжлөл, 700 000₮
- ③ Өргөмжлөл, 500 000₮

СУДЛААЧ

- ① Өргөмжлөл, 2 000 000₮
- ② Өргөмжлөл, 1 600 000₮
- ③ Өргөмжлөл, 1 300 000₮

Хурлын үе шат:

1-р шат

Зохион байгуулах комисс бүтээлийг хэвлэмэл болон файл хэлбэрээр хүлээн авч судалгааны ажлыг дүгнэх.

2-р шат

Монголбанк болон гадны төлөөлөгч нараас бүрдсэн багаар шүүлгэж дүнг гаргах, шалгарсан бүтээлүүдийг Монголбанкны албан ёсны вебсайт, социал сувгуудаар олон нийтэд түгээнэ.

Холбоо барих мэдээлэл:



+976 11-310-119
+976 11-310-081

2020 оны 5 сарын 01-ний өдрийн 18.00 цаг хүртэл

Монголбанкны "Б" байр
Олон нийтийн боловсрол,
мэдээллийн төв

essay@mongolbank.mn
www.mongolbank.mn




20000 Төгрөгийн сайжруулсан дэвсгэртийн хамгаалалтын таних тэмдгүүд



ШИНЭ

1 Усан хээ


Гэрлийн эсрэг барихад тод харагдах Чингис хааны хөрөг болон МБ гэсэн үсэгтэй усан хээг сайжруулсан.



ШИНЭ

2 3 хэмжээст, хөдөлгөөнт гадаргуутай тууз

Соёмбо, өлзий хээ, арга билиг, алхан хээ, Монголбанк гэсэн бичил текстүүд бүхий ногоон өнгийн тууз нь 3 хэмжээстэй бөгөөд дэвсгэртийг дээш, доош, баруун, зүүн тийш налуу хөдөлгөхөд эдгээр дүрсүүд хөдөлж, зарим нь цаана гүн хэсэгт харагдана.



ШИНЭ

3 Өнгө нь хувирагч элемент

Дэвсгэртийн нүүрэн талд байх 4 морьтон баатрын дүрс нь 3 хэмжээстэй бөгөөд дээш, доош, баруун, зүүн тийш хөдөлгөхөд цаад гүн хэсэгт алтлаг шар болон ногоон өнгийн цагирагнууд ээлжлэн солигдож харагдана.



ШИНЭ


4 Гялгар судал

Дээш, доош налуу хөдөлгөхөд алтлаг шаргал өнгөөр гялалзах өлзий хээ харагдана.



5 Товгор элемент


- МОНГОЛ УЛС гэсэн эвхмэл монгол бичиг,
- Чингис хааны хөрөг болон хөрөгний ар талын фон,
- Соёмбо,
- 20000-ын араб болон уйгаржин тоо,
- Гарын үсэг,
- Монголбанк, хорин мянган төгрөг гэсэн уйгаржин монгол бичилтүүд нь хурууны үзүүрт тэмтрэгдэнэ.



ШИНЭ

6 Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан элемент

Баруун, зүүн ирмэг дэх 8 ширхэг ташуу товгор зураас нь 20000-тын дэвсгэртийг илэрхийлэх бөгөөд хурууны үзүүрт тэмтрэгдэнэ.



7 Давхцаж харагдах дүрс

Дэвсгэртийн нүүр болон ард талд байрлах Чингис хааны Гэрэгэ дэх дугуй дүрсүүд зөрүүгүй давхцана.

